



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР

НЭГ хот стандарт

2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН УЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2022 он

ГАРЧИГ

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2-3
ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ:	
2.1 Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлжж үндсэн чиглэлийн хэрэгжилт.....	3-6
2.2 Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт.....	6-10
2.3 Нийслэлийн 2022 онд хөгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт.....	10-13
2.4 Нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилт.....	13-19
ГУРАВ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ.....	19
3.1 Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх чиг үүргийн хэрэгжилт хүрээнд.....	19
3.2 Хотын стандартыг боловсруулах, эрх бүхий байгууллагаар батлуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих чиг үүргийг хүрээнд.....	19-21
3.3 Хотын стандартыг хэрэглэх, дагаж мөрдөхөд чиглэсэн удирдамж, арга зүйн тогтолцоог хөгжүүлэх чиг үүргийн хүрээнд.....	21-22
3.4 Хотын стандартын баримт бичиг бичгийн лавлагаа, мэдээллийн санг бүрдүүлэн хөтлөх арга хэмжээний хэрэгжилт.....	22
3.5 Хотын стандарт батлуулах талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, арга зүйгээр хангах.....	22
3.6 Хотын стандартын талаарх сургалт, сурталчилгаа.....	22-28
3.7 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс.....	28
ДӨРӨВ. ТОГТООЛ ШИЙДВЭР, ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ.....	28
4.1 Дээд газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт.....	28-29
4.2 Нийслэлийн Засаг даргын захирамжийн хэрэгжилт.....	29-35
4.3 Нийслэлийн Засаг даргын үүрэг даалгаврыг биелэлтийн хэрэгжилт.....	35-36
4.4 Нийслэлийн онцгой комиссоос өгөх үүрэг даалгаврын хэрэгжилт.....	36-37
ТАВ. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ.....	38
5.1 Ил тод, нээлттэй байдлыг хангуулах.....	38-39
5.2 Хүний нөөцийг хөгжүүлэх.....	39-42
5.3 Дотоод ажил, үйлчилгээ.....	42-48
5.4 Дотоод хяналт шалгалтын үйл ажиллагааны хэрэгжилт.....	48-49
5.5 Хотын стандартыг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хэрэгжилт.....	49-52
ЗУРГАА. ДҮГНЭЛТ.....	52

НЭГ. БАЙГУУЛЛАГЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 ЭРХЭМ ЗОРИЛГО

Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх замаар хувь нэмрээ оруулна.

1.2 АЛСЫН ХАРАА

Нийслэл хотын иргэдийн амьдралын чанарыг сайжруулах хотын стандартын тогтолцоог хөгжүүлнэ.

1.3 БИДНИЙ ҮНЭТ ЗҮЙЛС

Эдгээр үнэт зүйлс нь алсын хараандаа хүрэхэд бидний үйл ажиллагааг цаг ямагт чиглүүлж байх зүг заагчийн үүрэг гүйцэтгэнэ.

ЁС ЗҮЙ	<i>БИД төрийн алба, хувь хүний ёс зүйг дээдлэн сахиж, үнэнч шударга, ил тод байдлыг эрхэмлэн, бие биедээ, хамтран ажиллагсад нартай харилцан итгэлцилийг бэхжүүлж ажиллана.</i>
МАНЛАЙЛАЛ	<i>БИД үндэсний эрх ашгийг дээдлэн хүндэтгэж, нийтийн сайн сайхны төлөө, нийгэмд зөрөгөөн өөрчлөлтийг авчрах итгэл үнэмшилийн төв манлайлаж байна.</i>
ХАРИУЦЛАГА	<i>БИД ажил, үүрэг, чанартай гүйцэтгэлийг ухамсарлаж, гарах үр дүнд сууринсан хариуцлагыг хүлээж ажиллана.</i>
УР ЧАДВАР	<i>БИД ажилтан бүрийн мэргэшсэн, бүтээмжтэй, эмх цэгцтэй, үр дүнтэй, зохион байгуулалттай, чадварлагтай суралцаагчийг дэвжиж байгууллагын хэв шинжийг хадгална.</i>
ХАМТ ОЛОН	<i>БИД багийн ажиллагааг эрхэмлэж, нийтээрээ чадварлаг хамт олон болж, мэргэжлийн урам зоригоор дүүрэн ажлын орчныг бий болгоно.</i>

1.4 ГАЗРЫН БҮТЭЦ

Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний зарим агентлагийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн батлах тухай” А/1059, 2022 оны “Дүрэм батлах тухай” А/112 дугаар захирамж, Газрын даргын 2022 оны Б/06 дугаар тушаалаар удирдлага 1, хэлтэс 6, нийт 59 албан хаагчийн орон тоотой байхаас 2022 онд 43 албан хаагчидтай ажиллав.

№	Бүтэц, зохион байгуулалт	Албан хаагчдын тоо		
		Батлагдсан орон тоо	Ажиллаж байгаа	Сул орон тоо
1	Удирдлага /Газрын дарга/	1	1	-
2	Захиргаа, санхүүгийн хэлтэс	13	8	5
3	Байгаль орчны стандартын хэлтэс	8	6	2
4	Хотын хөгжлийн стандартын хэлтэс	8	5	3
5	Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтэс	8	6	2

6	Стандартын хэрэгжилт хяналтын хэлтэс	13	10	3
7	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс	8	7	1
Нийт		59	43	16

1.5 ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ

Улаанбаатар хотыг урт, дунд хугацаанд хөгжүүлэх бодлогын чиглэл, хөтөлбөр, төслүүдийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд үр ашигтай, үр нөлөөтэй байдлыг хангуулахад чиглэсэн хотын стандартуудыг боловсруулж батлуулан, хотын стандартын тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлнэ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хариуцлагын гэрээ байгуулан 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөнд 4 бүлэг арга хэмжээний, 18 зорилтын, 59 ажил үйлчилгээг хийж гүйцэтгэн Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид нийлүүлхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлан ажиллалаа. Үүнд:

- ❖ 1. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр болон бодлогын бичиг баримтад тусгагдсан зорилт, арга хэмжээн хэрэгжүүлэх /1 зорилт, 2 ажил үйлчилгээний биелэлт 100 хувь/
- ❖ 2. Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн засаг дарга бөгөөд улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ /9 зорилт, 15 ажил үйлчилгээний биелэлт 100 хувь /
- ❖ 3. Байгууллагын стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөсөн арга хэмжээ /3 зорилт, 24 ажил үйлчилгээний биелэлт 100 хувь /
- ❖ 4. Төрийн байгууллагын нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ /6 зорилт, 9 ажил үйлчилгээний биелэлт 100 хувь/
- ❖ Монгол Улсын Засгийн газрын зарим чиг үүргийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэхээр 3 сайдтай гэрээ байгуулан ажиллалаа. Үүнд:
 - ✓ а/. 2022 онд Монгол улсын Шадар сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд байгуулсан 2022 онд Засгийн газар зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ. /Биелэлт 100 хувь/
 - ✓ б/. Монгол улсын Барилга, хот байгуулалтын сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд байгуулсан 2022 онд Засгийн газар зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, /биелэлт 100 хувь/
 - ✓ в/. Монгол улсын Эрчим хүчний сайд болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын хооронд байгуулсан 2022 онд Засгийн газар зарим чиг үүргийг нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээ, /биелэлт 100 хувь/

ХОЁР. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

2.1 НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ:

ОРШИЛ. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтооолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн

ундсэн чиглэл” дунд хугацааны бодлогын баримт бичиг, 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 202-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр тус тус батлагдсан. “Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг “Алсын Хараа 2050” Монгол улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн бүтцийн дагуу 9 бүлгийн хүрээнд 9 зорилго, 66 зорилт, 355 шалгуур үзүүлэлтүүдийг хангахаар 186 хүрэх үр дүнг тодорхойлон боловсруулж НИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 02/09 дугаар тогтоолоор батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.

2.1.1 Тав. ЗАСАГЛАЛ

Зорилго 5. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж иргэдийн оролцоог хангасан авлигаасангид, үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлэх замаар сайжруулна.

5.3.1 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байх ажлын хүрээнд:

- ❖ Чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 олон улсын стандартыг байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ач холбогдол, үр дүн сэдэвт сургалтыг 2021 оны 06 дугаар сарын 21, 25, 30-ны өдрүүдэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлага, хэлтсийн дарга нар нийт 131 албан хаагчийг хамруулан зохион байгуулсан. Одоогийн байдлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаабаатар хотын захирагчийн ажлын алба, Нийслэлийн сургалт, судалгааны төв, Хотын стандарт, хяналтын газар, Нийслэлийн байгаль орчны газар, Нийслэлийн дотоод аудитын газар, Ус сувгийн удирдах газрууд чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлээд байна.
- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу сургалтын зардал хасагдсан тул энэ жил сургалтын үйл ажиллагаа зохион байгуулаагүй болно.

2.1.2 Найм. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ

Зорилго 8. Хүн амын нутагшил суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж, бус орон нутгийн хөгжлийн уялдааг ханггуулна.

8.1.7 Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байх ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал ирүүлэх албан бичгийг судлан Улс нийслэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан “Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх” ажлыг хэрэгжүүлэх санал өгөв. Хот байгуулалт, хөгжлийн газар, Ерөнхий архитекторын ажлын албанд 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/529 бичгээр тус ажлын талаар тодруулга авахад Нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд судалгааны ажлыг төсвийн хамт тусгуулахаар санал хүргүүлсэн байна.
- ❖ Бодлого боловсруулахад шаардлагатай судалгааны ажлын төсөв батлагдаагүйн улмаас судалгааны ажил хийгдээгүй. Хот байгуулалт, хөгжлийн газраас судалгааны ажилд шаардлагатай 120 сая төгрөгийн төсөв тооцоог боловсруулан нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд төсвийн хамт суулгуулахаар санал оруулсан.

2.1.3 Ес. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ

Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.

a/. 9.3.1 Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд сууринсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байх ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны А/60 тушаалаар байгуулсан төрийн үйлчилгээний хүнд, суртал, чирэгдлийг арилгах, үйлчилгээг боловсронгуй болгох үүрэг бүхий ажлын хэсэгт тус газрын 2 албан хаагч томилогдон ажиллаж байна.
- ❖ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг цахим үйлчилгээнд шилжүүлэх талаар Нийслэлийн Цахим хөгжил мэдээллийн технологийн газрын удирдлага, холбогдох албан хаагчид, зөвлөх байгууллага болох “Систем арт венчурс” ХХК-ийн албан хаагч нартай 2 удаа зөвлөлдөх уулзалт хийж, өнөөгийн нөхцөл байдлын процесийн зураглал үйлдэн, комиссын үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг, холбогдох маягтуудын загварыг хүргүүлсэн.
- ❖ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйлчилгээний танилцуулгыг 2022 оны 05 сарын 23-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтанд цахимаар хүргүүлсэн.

б/. 9.5.1 Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгын стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгох ажлын хүрээнд:

- ❖ Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөгдөх стандартын тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хот байгуулалтын үйл ажиллагаанд дагаж мөрдөгдөх эхний ээлжийн 38 хотын стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 18-26 дугаар тогтоолоор батлуулав. Батлагдсан стандартуудыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэн ажиллаж байна.
- ❖ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 18-26 дугаар тогтоолоор батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй дэд бүтцийг сайжруулахад чиглэсэн 5 бүлгийн 13 стандартад тусгасан. Дараагийн ээлжид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн 2 хотын стандартыг батлуулахаар бэлтгэлийг хангаад байна. Үүнд:
 - ✓ UCS 1001A Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж
 - ✓ UCS 1001C Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн техникийн зураг төсөл байна.
- ❖ Төрийн болон нийгмийн үйлчилгээний барилгыг хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг нэвтрүүлэх ажлын суурь судалгааны хүрээнд хороо, өрхийн эмнэлгийн барилга байгууламж, гадна орчны хүртээмжтэй дэд бүтцийн суурь судалгаа хийж, хорооны байрны нийт 98 асуумж, Өрхийн эмнэлгийн нийт 100 асуумжтай шалгуур хуудсыг боловсруулж 9 дүүргийн 171 хороонд хүргүүлснээс нийт 149 хороо, 111 өрхийн эмнэлэгт хүртээмжтэй дэд бүтцийн стандарт хангагдаагүй тухай үр дүн гарч, судалгааны тайланг нэгтгэв. Эдгээр барилга байгууламжийг стандартад нийцүүлж хүртээмжтэй болгохын тулд

засвар, тохижилтын ажил хийхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул энэ ажил ирэх жилүүдэд хийгдэхээр хүлээгдэж байна.

в/. 9.5.2 Ногоон барилгын стандартын ажлын хүрээнд:

- ❖ Ногоон барилгын стандартыг боловсруулж, нэвтрүүлэх чиг үүргийн хүрээнд дараах төслүүдэд санал хүргүүлэв.
- ❖ Улаанбаатар хотын гэр хорооллын дэд төвүүдэд орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хорооллыг үе шаттайгаар барилгажуулах ажлын хүрээнд Баянхшуу дэд төвийн эхний ээлжийн эко хорооллын концепц төлөвлөлтийн баримт бичгийн төслийг судалж стандарт, нормд нийцүүлэх талаар санал өгч 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн албан бичгээр санал хүргүүлэв.
- ❖ Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан боловсруулж буй барилгын материалын техникийн нөхцөл, химиин шинжилгээний аргын тухай 8 стандартын төсөлд саналыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 01/57 дугаарын албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.

г/. 9.5.3 Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байх ажлын хүрээнд:

- ❖ Хотын стандарт, хяналтын газраас 2022 онд нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах шаардлагатай 12 чиглэлийн судалгаа хийгдсэн байна. Нийт 4651 байршил судалгаа хийгдсэн бөгөөд сайжруулах шаардлагатай 3598 байршил байгаа нь судалгааны үр дүнд тогтоогдсон.
- ❖ Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулж, эрсдлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/585 дугаар захирамжийн дагуу газар ашиглалтыг сайжруулах, авто замын түгжрэлийг бууруулах, явган хүний зам, ногоон байгууламж, нийтийн зээмшлийн зам, талбайг нэмэгдүүлэх зорилгоор хууль, журам зөрчсөн, стандарт шаардлагад нийцээгүй хашаа, хайс барьсан зөрчилтэй 376 байршилаас дүүргүүдийн 58 байршилд дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд 5 албан хаагч хашаа, хайсыг буулгуулж, зөрчлийг арилгуулав. 2022 онд иргэдийн амьдрах орчны аюулгүй байдал зөрчигдсэн талаар нийт 142 иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас өргөдөл, гомдол ирсэн ба холбогдох хууль журмын дагуу шийдвэрлэсэн.

2.2 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” дунд хугацааны бодлогын баримт бичиг, 24 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 202-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр тус тус батлагдсан.

а/. 4.1.4 дэх заалт: Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангах ажлын хүрээнд:

- ❖ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу байгууллагын төсөв, зардлын санхүүжилт, хүний нөөц, орон тооны өөрчлөлтийн мэдээлэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлэг, холбогдох тайлбарыг <https://shilendans.gov.mn/> цахим

хуудсанд сар бүр тогтмол нийтэлж “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангулан ил тод, нээлттэй байдлыг хангулан ажиллав.

б/. 5.1.2.1 дахь заалт: Хотын тоосжилтыг бууруулж, иргэдэд ээлтэй орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Иргэдийн амарч зугаалах тав тухтай орчныг бүрдүүлэх хүрээнд хийх тохижилт, бүтээн байгуулалтын ажилд мөрдүүлэх хотын стандартуудыг боловсруулж Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар батлуулсан. Үүнд:
 - Хүүхдийн тоглоомын талбай
 - Чийрэгжүүлэх талбай
 - Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө /сандал, сүүдрэвч, хөшөө дурсгал
 - Ногоон байгууламж гэх мэт батлагдсан стандартуудыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрээс эхлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулж байна. Энэ хүрээнд “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-д холбогдох нутгийн захиргааны байгууллагуудад дээрх стандартуудыг мөрдүүлэх талаар мэдээлэл, өгч арга зүйгээр ханган ажилласан.

в/. 5.3.6 дахь заалт: Нийслэлийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, аюулгүй байдлыг хангах стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд:

- Ундны усны эх үүсвэрийг хамгаалах, үерийн усны барилга байгууламж, хөв цөөрөмтэй холбоотой асуудлаар “Усны барилга байгууламж” бүлгийн 2 хотын стандартын төслийн ажлын даалгаврыг боловсруулав. Үүнд: “Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага”
- “Нийслэлийн ундны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага”
- Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилтын хүрээнд “Ногоон байгууламж” бүлгийн 5 төрлийн хотын стандартыг боловсруулсан. Стандартын төслийг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн стандартыг нийслэлийн хэмжээнд мөрдүүлэн ажиллаж байна.
- “Хот доторх оршуулгын газруудын өнөөгийн байдлын судалгаа”-нд үндэслэн “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартын төслийг боловсруулсан.
- 2022 онд боловсруулах Хотын стандартын баримт бичгийн жагсаалтад тусгагдсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн гарын авлага” хотын стандартын төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулсан.

г/. 6.1.3 дахь заалт: Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн иргэд, олон нийтэд нээлттэй болгон, тэгш хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох талаар холбогдох

байгууллагуудад санал өгөх, чиг үүргийн хүрээнд хамтран ажиллах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын А/60 тушаалаар байгуулсан төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг арилгах, үйлчилгээг боловсронгуй болгох арга хэмжээг авч хэрэгжүүлэх ажлын хэсэгт 2 албан хаагч томилогдон ажилласан.

❖ Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг цахимжуулахтай холбоотой Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газрын дарга, албан хаагчид болон системийн хөгжүүлэгч байгууллагатай 2 удаа хамтарсан уулзалт хийж барилга ашиглалтад оруулах үйл ажиллагааны явцын зураглал, холбогдох хууль, дүрэм, журмын заалт, дэлгэрэнгүй мэдээллийг боловсруулж Нийслэлийн Цахим хөгжил, мэдээллийн технологийн газар болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт албан бичиг, цахим шуудангаар хүргүүлсэн.

ð/. 6.1.5 дахь заалт: Хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

❖ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд мөрддөг стандарт, норм нормативын баримт бичгийн судалгааг 2019, 2021, 2022 онуудад нийт 3 удаа хийсэн.

- Нийслэлийн нутгийн захиргааны 84 байгууллагад 2080 стандарт, норм дүрмийг мөрдүүлэн ажиллаж байгаагаас шинээр боловсруулах шаардлагатай 6 стандарт, 29 БНБД, шинэчлэх шаардлагатай 184 стандарт, 10 барилгын норм ба дүрмийн саналыг 2021 онд Стандартчилал, хэмжил зүйн газар, Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. 2022 онд 96 байгууллагаас авсан судалгааны үр дүнд шинээр боловсруулах шаардлагатай 10 стандарт, 10 БНБД, шинэчлэх шаардлагатай 26 стандарт, 51 барилгын норм ба дүрмийн санал ирүүлсэнийг Стандартчилал хэмжилзүйн газар, Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн.
- Дээрх судалгаа, саналуудын үр дүнд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 2 стандартын баримт бичиг хүчингүй болсон, 4 БНБДүрэм Барилга, байгууламжийн норм нормативын сангийн төлөвлөгөөнд туссан байна.

Үүнд:

- БНБД 81-11-06 Усны барилга байгууламжийн зураг төслийн жишиг үнэ;
- БД 31-101-00 Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар;
- БД 31-102-00 Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар;
- БНБД 31-08-05 Дуу, дулаан тусгаарлалтын ажил.

❖ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 5 дугаар чуулганаар нийслэлийн хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандартыг баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр тогтоосон. Батлагдсан стандартыг мөрдүүлэх бэлтгэл хангуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамжаар “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан 11 бүлэг 25 арга хэмжээг хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Засаг

даргын Зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт хэрэгжилт 87 хувьтай дүгнэгдсэн бөгөөд цаашид хотын стандартыг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлж, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хотын стандартыг мөрдүүлэх, сургалт арга зүйгээр хангах арга хэмжээг тусгахаар үүрэг даалгавар өгөгдсөн.

- ❖ Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/169 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь Барилга, байгууламж норм, нормативын баримт бичиг “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 31-23-22/ болон бусад холбогдох норм, дүрэм, стандартад заасан саадгүй байдал, хүртээмжийн байдлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон зургаан дүүргийн Засаг даргын тамгын газрын нийт 7 барилга байгууламжид 12 төрлийн 51 шалгуураар үнэлгээ хийсэн.
- ❖ Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 230 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчны шаардлага MNS6055:2009 болон бусад холбогдох норм, дүрэм, стандартыг хангасан эсэх, саадгүй байдал, хүртээмжийн байдалд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон зургаан дүүргийн Засаг даргын тамгын газрын нийт 7 барилга байгууламжид 6 төрлийн 27 шалгуураар үнэлгээ хийсэн.
- ❖ Нийслэлийн төр, захиргааны зарим барилгуудад саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээний үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу нэгтгэн санал, дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр ажлын хэсэгт хүргүүлсэн.
- ❖ Газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 9 бүлгийн 15 хотын стандартын баримт бичгийн төслийг боловсруулсан. Газрын даргын 2022 оны үнэлгээний хороо байгуулах тухай А/23 дугаар тушаалын дагуу зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан.
- ❖ Дээрх стандартын төслүүдийг 2023 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

e/. 6.1.6 дахь заалт: Ногоон барилгын стандартыг шинээр боловсруулж мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Ногоон барилгын стандартыг боловсруулахад дараах байдлаар санал өгч хамтран ажиллав. Үүнд:
 - Улаанбаатар хотын гэр хорооллын дэд төвүүдэд орлогод нийцсэн ногоон орон сууцны эко хорооллыг үе шаттайгаар барилгажуулах ажлын хүрээнд Баянхшуу дэд төвийн эхний ээлжийн эко хорооллын концепц төлөвлөлтөд чиг үүргийн хүрээнд санал боловсруулан Улаанбаатар хотын орлогод нийцсэн ногоон орон сууц ба Дасан зохицох чадвар бүхий Хотын шинэчлэл салбарын төсөлд 2022 оны 01дүгээр сарын 31-ний өдрийн 01/48 дугаар албан бичгээр саналыг хүргүүлэв.
 - Барилгын хөгжлийн төвөөс ирүүлсэн Барилга байгууламжийн норм, нормативын сангийн 2021 оны төлөвлөгөөнд тусгагдан боловсруулж буй барилгын материалын техникийн нөхцөл, химийн шинжилгээний аргын

тухай 8 стандартын төсөлд саналыг 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 01/57 дугаар албан бичгээр хүргүүлэв.

ё/. 6.2.1 дахь заалт: Дагуул, хая хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлэн хотын төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал ирүүлэх албан бичгийг судлан Улс нийслэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан "Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх" ажлыг хэрэгжүүлэх санал өгөв.
- ❖ Хот байгуулалт, хөгжлийн газар, Ерөнхий архитекторын ажлын албанад 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/529 бичгээр тус ажлын талаар тодруулга авахад Судалгааны ажлыг төсвийн хамт нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулж батлуулахаар санал хүргүүлсэн тухай 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 02/3655 тоот бичгээр ирүүлсэн.

ж/. 6.2.3.5 дахь заалт: Иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулсан спортын барилга байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан Хотын стандарт, хяналтын газраас дараах арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд:
 - “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах шаардлага”- хотын стандартад заасан шалгуур үзүүлэлтийн дагуу нийслэлийн хэмжээнд нийт 305 сургуулийн дунд судалгаа хийхэд 75.5% нь стандартын шаардлага хангагүй гэсэн үр дүн гарсан. Судалгааны дүнг 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар танилцуулсан.
 - Сургуулийн гадна орчныг тохижуулахад мөрдүүлэх хотын стандарт болох UCS:1102B “Нийгмийн дэд бүтэц бүлгийн Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавигдах ерөнхий шаардлага”-ыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын V хуралдаанаар 2022 оны 03 дугаар сарын 34-ний өдөр батлуулан 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр тогтоосон.
 - Батлагдсан стандартыг мөрдүүлэхэд чиглэгдсэн “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ий хүрээнд “Иргэдийн ая тухтай орчин” зөвлөгөөнийг зохион байгуулсан. Энэхүү зөвлөгөөнд тус зорилтыг хариуцан хэрэгжүүлэгч Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Нийслэлийн Боловсролын газрын удирдлага, холбогдох албан хаагчдыг оролцуулж мэдээллээр хангав.

2.3 НИЙСЛЭЛИЙН 2022 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 11/31 дугаар тогтоолоор “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө” батлах тухай тогтоолын хүрээнд дараах ажил үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

2.3.1. Тав. Ногоон хөгжлийн бодлого

a/. 5.3.20 Үндны усны эх үүсвэрийг хамгаалах Үерийн усны барилга байгууламж, ус хуримтлуулах, хөв цөөрөм үүсгэх, ус дахин ашиглах хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Үндны усны эх үүсвэрийг хамгаалах, үерийн усны барилга байгууламж, хөв цөөрөмтэй холбоотой асуудлаар “Усны барилга байгууламж” бүлгийн 2 хотын стандартын төслийг боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, газрын даргаар батлуулсан. Үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу дараах 2 стандартын төслийг мэргэжлийн зөвлөх байгууллагуудтай хамтран боловсруулж дууссан. Үүнд:
 - ✓ “Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага”
 - ✓ “Нийслэлийн үндны усны эх үүсвэрийн хамгаалалтад тавигдах шаардлага” гэх 2 стандартын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэсэн.

б/. 5.3.21 Ногоон байгууламжийн техникийн ерөнхий шаардлага, төлөөлөлт хийх удирдамж, арга зүйн баримт бичиг боловсруулж мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Иргэдийн амьдрах орчныг сайжруулах зорилтын хүрээнд “Ногоон байгууламж” бүлгийн 5 төрлийн хотын стандартыг боловсруулсан. Дээрх стандартын төслийг 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдөр нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, батлуулж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн стандартыг мөрдүүлэн ажиллаж байна.

в/. 5.3.22 Хот доторх оршуулгын үйл ажиллагаа явуулдаг газрын орчны цэцэрлэгжүүлэлтийн орчны аюулгүй байдлыг хангах, хотын стандарт, норм, дүрмийг боловсруулж, мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ “Хот доторх оршуулгын газруудын өнөөгийн байдлын судалгаа”-нд үндэслэн 2022 онд “Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага” хотын стандартын 1 төслийг үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу мэргэжлийн зөвлөх байгууллагуудтай хамтран боловсруулж дууссан ба хотын стандартын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэсэн.

г/. 5.3.23 Уул уурхайн олборлолтын улмаас эвдэрсэн газрын хөрсөнд дахин сэргээлт хийх ерөнхий шаардлага, удирдамж арга зүйн баримт бичгийн төсөл боловсруулж, мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ 2022 онд боловсруулах Хотын стандартын баримт бичгийн жагсаалтад тусгагдсан “Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолтын улмаас эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн гарын авлага” хотын стандартын 1 төслийг үнэлгээний хорооны зөвлөмжийн дагуу мэргэжлийн зөвлөх байгууллагуудтай хамтран боловсруулж дууссан ба стандартын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч нэгтгэсэн.

2.3.2. Зургаа. Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого

а/. 6.1.23 Мөрдүүлэх боломжгүй, шаардлага хангахгүй стандартуудыг хүчингүй болгох ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд мөрддөг стандарт, норм нормативын баримт бичгийн судалгааг 2019, 2021, 2022 онуудад нийт 3 удаа хийсэн.

- ❖ Нийслэлийн нутгийн захиргааны 84 байгууллагад 2080 стандарт, норм дүрмийг мөрдүүлэн ажиллаж байгаагаас шинээр боловсруулах шаардлагатай 6 стандарт, 29 БНБД, шинэчлэх шаардлагатай 184 стандарт, 10 барилгын норм ба дүрмийн саналыг 2021 онд Стандартчилал, хэмжил зүйн газар, Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. 2022 онд 96 байгууллагаас авсан судалгааны үр дүнд шинээр боловсруулах шаардлагатай 10 стандарт, 10 БНБД, шинэчлэх шаардлагатай 26 стандарт, 51 барилгын норм ба дүрмийн санал ирүүлсэнийг Стандартчилал хэмжилзүйн газар, Барилгын хөгжлийн төвд тус тус хүргүүлсэн.
- ❖ Дээрх судалгаа, саналуудын үр дүнд 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 2 стандартын баримт бичиг хүчингүй болсон, 4 БНБДүрэм Барилга, байгууламжийн норм нормативын сангийн төлөвлөгөөнд туссан байна. Үүнд:
 - ✓ БНБД 81-11-06 Усны барилга байгууламжийн зураг төслийн жишиг үнэ;
 - ✓ БД 31-101-00 Эвдрэл гэмтэлтэй барилга байгууламжид инженерийн биет судалгаа явуулах аргачилсан заавар;
 - ✓ БД 31-102-00 Хуучин барилгын газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварыг үнэлэх заавар;
 - ✓ БНБД 31-08-05 Дуу, дулаан тусгаарлалтын ажил.

б/. 6.1.24 Хотын стандартыг батлуулж мөрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 5 дугаар чуулганаар хотын хэмжээнд мөрдүүлэх 9 бүлгийн 38 хотын стандарт баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэн ажиллаж байна.
- ❖ Батлагдсан стандартыг мөрдүүлэх бэлтгэл хангуулах зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр захирамжаар “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө”-г батлуулан 11 бүлэг 25 арга хэмжээт хэрэгжүүлсэн. Төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдөр танилцуулсан. Төлөвлөгөөний хэрэгжилт 87 хувьтай дүгнэгдсэн бөгөөд цаашид хотын стандартыг мөрдүүлэх ажлыг эрчимжүүлж нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө хотын стандартыг мөрдүүлэх, сургалт арга зүйгээр хангах арга хэмжээг тусгахаар үүрэг даалгавар өгөгдсөн.

в/. 6.1.25 1990 оноос өмнө баригдсан олон нийтийн барилга байгууламжийн хүртээмжийн чанарыг сайжруулж, налуу замтай болгох ажлын хүрээнд:

- ❖ Барилга, хот байгуулалтын яамны төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/169 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг нь Барилга, байгууламж норм, нормативын баримт бичиг “Барилга байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийг төлөвлөх” /БНБД 31-23-22/ болон бусад холбогдох норм, дүрэм, стандартад заасан саадгүй байдал, хүртээмжийн байдлыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон зургаан дүүргийн Засаг даргын тамгын газрын нийт 7 барилга байгууламжид 12 төрлийн 51 шалгуураар үнэлгээ хийсэн.
- ❖ Барилга хот байгуулалтын сайдын 2022 оны 230 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зайд, орчны шаардлага МНС6055:2009 болон бусад холбогдох норм, дүрэм, стандартыг хангасан эсэх, саадгүй байдал, хүртээмжийн байдалд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон зургаан дүүргийн Засаг даргын тамгын газрын нийт 7 барилга байгууламжид 6 төрлийн 27 шалгуураар үнэлгээ хийсэн.
- ❖ Нийслэлийн төр, захиргааны зарим барилгуудад саадгүй байдал, хүртээмжийн үнэлгээний үр дүнг шалгуур үзүүлэлтийн дагуу нэгтгэн санал,

дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг боловсруулан 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр ажлын хэсэгт хүргүүлсэн.

г/. 6.1.26 Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрддөг стандартыг хангуулах, хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг 5 багц сэдвийн хүрээнд боловсруулж мөрддөх ажлын хүрээнд:

- ❖ Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн А/22 дугаар тушаалын дагуу Хотын стандартын 9 бүлгийн 15 баримт бичгийн төслийг боловсруулсан ба баримт бичгийн төслүүдийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар санал авч байна.

д/. 6.2.8 Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Монгол Улсын Засгийн газар, Европын сэргээн босголт, хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрийн санал ирүүлэх албан бичгийг судлан Улс нийслэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан "Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх" ажлыг хэрэгжүүлэх санал өгөв.
- ❖ Хот байгуулалт, хөгжлийн газар, Ерөнхий архитекторын ажлын албанд 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 01/529 бичгээр тус ажлын талаар тодруулга авахад Судалгааны ажлыг төсвийн хамт нийслэлийн 2023 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгувалж батлуулахаар санал хүргүүлсэн тухай 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 02/3655 дугаар албан бичгээр ирүүлсэн.

2.4 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГУУЛАХ

2022 оны байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Засгийн газрын зарим чиг үүргийг Нийслэл хариуцан хэрэгжүүлэх 3 хамтран ажиллах гэрээ байгуулсан бөгөөд биелэлтийг гарган ажиллав. Үүнд:

2.4.1/. ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭНД 1 ЗААЛТЫН БИЕЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

- ❖ 3.2.12 Төвөгшил бага болон дунд зэргийн эрчим хүчний барилга байгууламжийг техникийн болон улсын комиссд хүлээж авахад тухайн орон нутгийн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх тусгай зөвшөөрөл бүхий үйлдвэр компаниудын мэргэжлийн хүмүүсийг оруулах
- ❖ МУ-ын Засгийн газрын 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/861 дүгээр захирамжийн дагуу Бага, дунд, өндөр төвөгшилтэй ангиллын Эрчим хүчний барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ТӨХК, болон бусад эрчим хүчээр хангах Тусгай зөвшөөрөлтэй аж ахуй нэгж байгууллагуудын ерөнхий инженер, болон хариуцсан инженерүүдийг татан оролцуулан ажиллаж байна. 2022 оны эхний хагас жилийн байдлаар 437 байршилд ажиллаж, дүгнэлт баталгаажуулан ажиллав.

2.4.2/. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД БОЛОН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ 8 ЗААЛТЫН БИЕЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

а/. Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг

ашиглалтад оруулах дүрэм"-ийн хэрэгжилтийг хангуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудын дэлгэрэнгүй мэдээллийг нэгдсэн хүснэгтээр гаргаж ирүүлэх., Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 353 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн ашиглалтын дүрэм"-ийн хэрэгжилтийг ханган ажиллаж, тайланг ирүүлэх.

- ❖ Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/861 дүгээр захирамж батлагдсан. Комиссын бүрэлдэхүүнд төрийн байгууллага-11, төрийн бус байгууллага-4 төлөөллийг хамруулан ажиллаж байна.
- ❖ 2022 онд тус газарт 1277 барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт ирсэн. Үүнд:
 - Барилга байгууламж-428
 - Цахилгаан хангамж-534
 - Засвар, тохижилт-315 байна.

904 иргэн аж, ахуй нэгж байгууллагуудын хүсэлтийг шийдвэрлэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.

Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар “Аргачлал батлах тухай” тушаалын дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг 130 талбараар орон зайн мэдээллийн санд бүртгэн, 8 байгууллагад улирал бүр дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

- ✓ Барилга хот байгуулалтын яам
- ✓ Авилгатай тэмцэх газар
- ✓ Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- ✓ Барилгын хөгжлийн төв
- ✓ Татварын ерөнхий газар
- ✓ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
- ✓ Нийслэлийн орон сууц бодлогын газар
- ✓ Нийслэлийн статистикийн газар

6/. Барилгын материалын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний нэр төрөл, хүчин чадал, ашиглалт, ажиллах хүчиний мэдээлэл, үйлдвэрлэлийн борлуулалт, тусгай зөвшөөрөл, тохирлын гэрчилгээтэй эсэх дэлгэрэнгүй судалгаа гаргах.

- ❖ Нийслэлийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын 128 талбай дах төрөл, байршлыг орон зайн мэдээллийн санд байршуулж, агаарын бохирдол, хөрсний бохирдолд нөлөөлөх нөлөөллийн судалгаа гаргав. Үүнд:
 - Барилгын материал-40
 - Дайрга-46
 - Хайрга -3
 - Шаварлаг нүүрс-3
 - Шавар-19
 - Элсэрхэг шавар-4
 - Элс-8
 - Элс хайрга-4

Дээрх үйлдвэрүүдийн байршилаар авч үзвэл:

- Баганур-3
- Багахангай-3

- Баянзурх-8
- Налайх-47
- Сонгинохайрхан-30
- Сүхбаатар-2
- Хан-Уул 35

Холбогдох арга хэмжээг авч ажиллах тухай албан бичгийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар болон Нийслэлийн Байгаль орчны газруудад тус тус хүргүүлэн ажиллав.

в/. “Барилгын салбар дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд хөтөлбөр”-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аяныг зохион байгуулан тайлагнах.

- ❖ “Барилгын орчны аюулгүй байдлыг хангуулах” талаар Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар, Хот байгуулалт хөгжлийн газар, Хотын стандарт, хяналтын газруудаас хамтарсан “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг 2022 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр гаргасан. Нийслэлийн нутаг дэвсгэрт 44 албан хаагч барилга угсралтын үйл ажиллагаа эрхлэгч 338 аж ахуй нэгж байгууллагуудад хотын стандартын хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөвлөгөө мэдээллийг өгч, 109 аж ахуй нэгж байгууллага зөрчлөө арилгасан байна.

г/. Барилга угсралтын үе шатны ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг “Төслийн удирдлагын арга зүйн заавар” MNS:ISO 21500 стандарт, Барилгын чанарын менежментийн тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах

- ❖ Төслийн удирдлагын арга, зүйг шинэчлэх, барилгын менежментийн тогтолцоог сайжруулах ажлыг аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлах, таниулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын “Зөвлөгөөн зохион байгуулах тухай” А/1393 дугаар захирамжийн дагуу “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ий салбар зөвлөгөөн болох “Барилгын аюулгүй орчин” зөвлөгөөнийг 2022 оны 11 сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Нийт 230 төрийн болон барилга угсралт, зураг төслийн гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагууд оролцсон. Үүнд:
 - Барилга угсралтын 136 байгууллага
 - Зураг төсөл зохиогч 38 байгууллага
 - Төрийн байгууллагын 56 төлөөлөл
- ❖ Зөвлөгөөнөөр “Бүтээн байгуулалтын үйл ажиллагааг удирдах ухаалаг загварчлал”, хотын стандартын тогтолцоо, ач холбогдол, барилгын салбарт шинээр нэвтрүүлж буй технологи, барилгын ажлын аюулгүй ажиллагаа зэрэг сэдвээр илтгэл танилцуулга хийж мэдээлэл өгсөн.


д/. Барилгын материал үйлдвэрлэгчдийн зөвлөгөөнөөс гарсан төлөвлөгөөний 2.2.-д тусгагдсан “Чулуу бутлан ангилах үйлдвэр, бетон зуурмагийн үйлдвэр, бетон эдлэлийн үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх” арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх.

- ❖ Нийслэлийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төвд дээрх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын мэдээллийг гаргах, цаашид тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудыг дэмжиж ажиллах талаар уулзалт зохион байгуулав.

- ❖ Олон улсын хөдөлмөрийн байгууллагын "Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай" 1988 оны 167 дугаар конвенцыг сурталчлах, хэрэгжилтийн тайлан гаргах.
- ❖ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 18 дугаар тогтоолоор "Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах техникийн ерөнхий шаардлага"-ыг батлуулсан. 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдүүлэхтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1393 дугаар захирамжийг батлуулж, хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчлах 5 салбар зөвлөгөөн зохион байгуулж ажиллав.
- ❖ Барилгын орчны аюулгүй үйл ажиллагаа, хотын стандартыг таниулах зорилгоор "Барилгын аюулгүй орчин" сэдэвт зөвлөгөөнийг 2022 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж төрийн болон хувийн хэвшлийн 230 аж ахуйн нэгж, байгууллагыг хамруулав. Үүнд:
 - Барилга угсралтын компани – 136
 - Зураг төслийн компани – 38
 - Төрийн байгууллага – 56 /Хот байгуулалт хөгжлийн газар, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба, Барилгын хөгжлийн төв/
- ❖ Тус зөвлөгөөнд хот төлөвлөлт, хот байгуулалт, ногоон байгууламж, иж бүрэн гудамж, нийгмийн дэд бүтэц зэрэг 8 бүлгийн 34 хотын стандартыг танилцуулж, 1801 хотын стандартыг оролцогчдод олгож ажиллав.

e/. Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар "Аргачлал батлах тухай" тушаалын хавсралтаар баталсан "Барилга байгууламж, гадна инженерийн шугам сүлжээг ашиглалтад оруулах ажлын хүрээнд барилгын салбарын нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд оруулах мэдээлэл" маягт, "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл" маягт, "Аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан барилга байгууламжийн мэдээлэл, бүртгэл" маягтын дагуу холбогдох мэдээг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлэх ажлыг зохион байгуулах;

- ❖ 2022 онд ашиглалтад орсон 904 иргэн аж, ахуй нэгж байгууллагуудын хүсэлтийг шийдвэрлэн, барилга байгууламжийг ашиглалтад оруулсан байна.
- ❖ Барилга хот байгуулалтын сайдын 2020 оны 55 дугаар "Аргачлал батлах тухай" тушаалын дагуу нийслэлийн нутаг дэвсгэрт ашиглалтад оруулсан 266 барилга байгууламжийн дэлгэрэнгүй мэдээллийг 130 талбараар орон зайн мэдээллийн санд бүртгэн, 8 байгууллагад улирал бүр дэлгэрэнгүй мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:
 - Барилга хот байгуулалтын яам
 - Авилгатай тэмцэх газар
 - Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
 - Барилгын хөгжлийн төв
 - Татварын ерөнхий газар
 - Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
 - Нийслэлийн орон сууц бодлогын газар



2.4.3. МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ НАРЫН ХАМТРАН БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ 5 ЗААЛТЫН БИЕЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

A. 3.45 НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД МӨРДӨГДӨЖ БАЙГАА СТАНДАРТУУДЫГ ШИНЭЧЛЭН БАТЛУУЛАХ, 41 СТАНДАРТЫГ ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ

- ❖ 2022 оны 04 дүгээр сарын 07-оос 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаудаас салбарын үйл ажиллагаанд дагаж, мөрддөг стандарт, техникийн зохицуулалт, норм, дүрмийн асуултлыг аван судалгааг нэгтгэн хийж гүйцэтгэв.
- ❖ Судалгаанд шинээр боловсруулах шаардлагатай 10 стандарт, шинэчлэн боловсруулах шаардлагатай 27 стандарт, шинээр боловсруулах шаардлагатай 10 БНБД, шинэчлэн боловсруулах шаардлагатай 51 барилгын норм ба дүрэм байна гэж санал ирүүлсэн. Саналыг Барилга хөгжлийн төвд 2022 оны 06 дугаар сарын 10-ний өдрийн 01/298 тоот дугаартай албан бичгээр уламжлан хүргүүлэв.
- ❖ 2022 оны 04 дүгээр сард хийсэн судалгааны үр дүнг Нийслэлийн Засаг Даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн Зөвлөлийн хурлаар танилцуулж, зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу дахин судалгаа авав.
- ❖ 2022 оны 09 дүгээр сарын 02-оос 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд Нийслэлийн нутгийн захиргааны 97 байгууллагаас салбарын үйл ажиллагаанд дагаж, мөрддөг стандарт, техникийн зохицуулалт, норм, дүрмийн судалгаа авав.
- ❖ Судалгаанд нийт 28 стандартыг шинэчлэн, 16 стандартыг шинээр, 6 Барилгын норм ба дүрмийг шинэчлэн боловсруулах тухай нийт 61 тухайлсан саналыг ирүүлсэн. Судалгааны тайлан мэдээг нэгтгэн, дүн шинжилгээ хийж НЗДТГазарт хүргүүлсэн.
- ❖ Мөн Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл 9.5 дахь заалтад туссаны дагуу 22 бүлгийн 97 стандартыг боловсруулан эхний ээлжид 38 стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралын 2022 оны 5 дугаар хурлаар батлуулан 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдүүлэн ажиллаж байна.

Б/. 3.46 ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШААРДАХГҮЙ БОЛСОН ҮЙЛЧИЛГЭЭНД ТАВИГДАХ СТАНДАРТЫГ ИРГЭН АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГАД МӨРДҮҮЛЭХ

Тусгай зөвшөөрөл шаардлагагүй 9 төрлийн 74 худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавигдах 74 шаардлагыг Онлайн бизнес төвийн системд үйлчилгээ тус бүрээр ангилан байршуулав.

- ❖ Үндэсний стандарт, Хотын стандартыг Нийслэлийн мэдээ мэдээллийн нэгдсэн портал сайт www.ulaanbaatar.mn цахим системд үндэсний 76, хотын стандартын 15 баримт бичгийг цахим системд байршуулсан.
- ❖ 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Баянгол дүүргийн 25 хорооны Засаг дарга, хэсгийн нийт ахлагч нарт “Явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилт угсралтад тавигдах шаардлага”, “Хүүхдийн тоглоомын талбай, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага” сэдвээр хотын стандартын талаар 30 хүнд сургалт зохион байгуулав.
- ❖ Үйл ажиллагаа эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийг холбогдох нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон дүүргүүдээс нийт 18664 мэдээлэл аван орон зайн мэдээлэлд 4904 суурь өгөгдлийг үүсгэн ажиллав.
- ❖ “Монголын явуулын хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн холбоо”-той хамтран Явуулын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хотын стандартын төсөл боловсруулах, засвар, сайжруулалт хийн стандартын эхний төсөл боловсруулагдav.

В/. 3.47 НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦОО (ISO 9001, ISO 18091, ISO 45001)-Г НЭВТРҮҮЛЭХЭД ШААРДЛАГАТАЙ ҮНДЭСНИЙ СТАНДАРТ, АРГА ЗҮЙ, ЗӨВЛӨМЖӨӨР ХАНГАХ

- ❖ Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудад 2020, 2021 онуудад Чанарын менежментийн тогтолцоо (ISO 9001, ISO 18091, ISO 45001) сэдэвт сургалтыг Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудад цахимаар арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 2022 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу сургалтын зардал танагдсан тул энэ жил сургалтын үйл ажиллагааг танхимаар зохион байгуулаагүй болно.
- ❖ 2022 онд Нийслэлийн Засаг даргын Сургалт, судалгаа олон нийттэй харилцах хэлтэс болон Ус сувгийн удирдах газрууд тус тус байгууллагынхаа үйл ажиллагаанд Чанарын менежментийн тогтолцоо (ISO 9001, ISO 18091, ISO 45001)-г нэвтрүүлсэн байна.

Г/. 3.48 НИЙСЛЭЛД ИТГЭМЖЛЭГДСЭН ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫГ БЭХЖҮҮЛЭХ

- ❖ Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 159 дүгээр захирамжаар байгуулагдсан. Стандартчилал, тохиролын үнэлгээний , бодлого, хэрэгжилтийг боловсронгуй болгох санал дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэгт ажиллан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохиролын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд тусгах саналыг 2022 оны 11 дүгээр сарын 02-ний өдрийн 01/164 тоот албан бичгээр Стандар, хэмжилзүйн газарт хүргүүлэв.

Д/. 3.49 ҮНДЭСНИЙ СТАНДАРТ, ТЕХНИК ЗОХИЦУУЛАЛТАД НИЙЦҮҮЛЭН ХОТЫН СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛАХ

- ❖ Стандарт хэмжил зүйн газарт 2022 оны 05 дугаар сарын 02-ний өдөр Хотын стандартын төсөлд санал авах тухай 02/288 дугаар албан бичиг хүргүүлсэн бөгөөд, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр Үндэсний стандарт, техник

- зохицуулалтад нийцүүлэн хотын стандартыг боловсруулах санал зөвлөмж ирүүлсэн.
- ❖ 38 хотын стандартыг ирүүлсэн саналын дагуу нийцүүлэн, хариу хүргүүлэн ажилласан.

Тус тус биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр хүргүүлж ажиллав.

ГУРАВ. ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

3.1 НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГОД НИЙЦҮҮЛЭН ХОТЫН СТАНДАРТЫН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ХҮРЭЭНД:

- ❖ Хотын стандартын тогтолцоо нь дараах үндсэн үйл явцаас бүрдэнэ. Үүнд:
 - суурь судалгаа,
 - төсөл боловсруулах,
 - хянан тохиолдуулах,
 - батлуулах,
 - хэрэгжилтийг хангуюлах гэх үндсэн чиглэлтэй.
- ❖ Нийслэл хот нь өөрөө Стандарттай байхаар хуульчлагдсан тул Хотын стандартыг боловсруулж, батлуулах харилцааг зохицуулсан дүрэм, журам байх шаардлагатай. Хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хэрэгжүүлэх зорилгоор Хотын стандартын үйл ажиллагааны журамын төслийг шинээр боловсруулсан, уг журмыг төсөлд Холбогдох чиглэлийн Төрийн байгууллагуудаас санал авч нэгтгэсэн. НИТХ-р батлуулахаар Нийслэлийг хөгжүүлэх 2023 оны төлөвлөгөөнд тусгасан.



Дээрхи журамыг батлагдах хүртэл хугацаанд Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1033 дугаар захирамжаар байгууллагдсан ажлын хэсэг Хотын стандартуудыг боловсруулж, батлуулах ажлыг хариуцан ажиллаж байна.

3.2. ХОТЫН СТАНДАРТЫГ БОЛОВСРУУЛАХ, ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГААР БАТЛУУЛАХ, ХЭРЭГЖИЛТЭД НЬ ХЯНАЛТ ТАВИХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД:


Нийслэлийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1033 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуюлах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд:

a/. Хотын стандартын **1 дүгээр ээлжийн 9 бүлгийн 38 стандартын төслийн санал авхаар **нийт 665** байгууллагад хүргүүлсэн.**

Саналыг асуулгад **337** байгууллагын **12840** ажилтан албан хаагчид **нийт 24083** саналыг ирүүлсэнээс:


- Дэмжэж, санал ирүүлсэн 27449
- Тухайлсан санал – 548
- Тухайн хотын стандартад хамааралгүй санал – 9414-н саналыг тусган **1 дүгээр ээлжийн 9 бүлгийн 38** стандартуудыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн V хуралдаанаар хэлэлцүүлэн **1 дүгээр ээлжийн 9 бүлгийн 38** хотын стандартуудыг батлуулсан.

6/.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1305 дугаар захирамжаар Хотын стандарт батлуулах ажлын хэсэг шинэчилэн байгуулагдсан, тус захирамжийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Хотын стандартын **2 дугаар ээлжийн 11 бүлгийн 29 стандартын төсөлд** иргэд олон нийтээс **30** хоногийн хугацаатай саналыг **Ulaanbaatar.mn**, **standard.ub.gov.mn** цахим хуудсуудаар дамжуулан **нийт 16332** саналыг иргэд, олон нийтээс ирүүлсэнээс:

- Дэмжэж, санал ирүүлсэн –15335
- Тухайлсан – 433
- Ерөнхий – 4737-н техникийн буюу тухайлсан саналыг хотын стандартын төсөлд тусгасан. Тус 29 стандартыг 2022 онд багтаан олон нийтийн хэлэлцүүлэгт оруулсаны дараа НИТХ-д өргөн барихаар төлөвлөсөн.



в/. Улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хүсэлт 2022 оны 01 дүгээр сараас эхлэн 2022 оны 12 дугаар сарыг хүртэл нийт **315 ирсэн хүсэлт, Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2022 оны А/861 дүгээр захирамжийн дагуу “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс”-ын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомж, норм дүрэм, стандарт шаардлагад нийцүүлэн зохион байгуулан ажиллаж, хотын стандартын хэрэгжилтийг **198** тохижилтын ажилд хяналт тавин, комиссын дүгнэлтийг баталгаажуулж ажиллалаа.**



3.3. ХОТЫН СТАНДАРТЫГ ХЭРЭГЛЭХ, ДАГАЖ МӨРДӨХӨД ЧИГЛЭСЭН УДИРДАМЖ, АРГА ЗҮЙН ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГҮҮРГИЙН ХҮРЭЭНД:

- ❖ Газрын даргын 2022 оны А/34 дүгээр тушаалын дагуу Улс, Нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон он дамжиж хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд хотын стандартын батлагдсан 9 бүлгийн 38 баримт бичгийн хүрээнд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулж мөрдүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах удирдамжийн хүрээнд нийслэлийн 9 дүүрэгт хүүхдийн тоглоомын болон сагсан бөмбөгийн талбайн тохижилт, явган замын ажил зэрэг тохижилт, бүтээн байгуулалтын ажилд тус тус хяналт тавьж ажиллав.
- ❖ Газрын даргын 2022 оны А/34-р тушаалаар:
 - Сонгинохайрхан дүүргийн 9 байршил,
 - Хануул дүүргийн 13 байршил,
 - Баянзүрх дүүргийн 21 байршил,
 - Сүхбаатар дүүргийн 5,
 - Чингэлтэй дүүргийн 6 байршил,
 - Багануур дүүргийн 5 байршил,
 - Налайх дүүргийн 11 байршил гээд **нийт 65** байршилд хийгдэж буй тохижилт бүтээн байгуулалтын ажлуудад батлагдсан стандартыг танилцуулан, арга зүйн зөвлөмж өгч ажилласан.





- ❖ **Нийслэл хотод үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ын үйл ажиллагаа, үйлчилгээний стандартыг мөрдөх, хэрэгжилтийг хангуулахад мэргэжил арга зүйгээр хангаж зөвлөн туслах ажлыг зохион байгуулах төлөвлөгөөний хүрээнд:**
 - Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар,
 - Баянгол, Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс,
 - Чингэлтэй дүүргийн Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтэс,
- ❖ **Стандартыг мөрдөх, хэрэгжилтийг хангуулахаар зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангаж ажлын хүрээнд худалдаа, үйлчилгээний үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгж байгууллагуудад стандартын ойлголтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, мөрдөх, хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулахаар төлөвлөгөөний хүрээнд:**
 - Нийслэлийн Захирагчийн ажлын алба,
 - 9 дүүргийн Засаг даргын тамгын газар,
 - Хүнс, худалдаа, үйлчилгээний хэлтсүүд
 - Хан-Уул дүүрэгт нийт 70 аж ахуй нэгж байгууллагад “Худалдаа, үйлчилгээний гадна орчин”, “Хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт орон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч байгууллагуудаас сэтгэл ханамжийн судалгаа аван ажиллав.



- ❖ **Налайх дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт үйл ажиллагаа эрхлэгч 108 иргэн, аж ахуйн нэгжийн амралт жуулчны бааз, гэр амралтад газар дээр** нь ажиллан үүссэн зөрчлийг арилгуулах, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх ажлыг хийж гүйцэтгэв. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар дараах хотын стандартуудыг танилцуулж, зөвлөн туслав:

- UCS 1701A:2022 Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент;
- UCS 1706A:2022 Барилгын хог хаягдлын менежмент;
- UCS 1401B:2022 Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавигдах техникийн шаардлага;
- UCS 1405B:2022 Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага;
- UCS 1410B:2022 Хашаа, хайс, хашлаганд тавигдах ерөнхий шаардлага;
- UCS 1203B:2022 Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах шаардлага.



3.4. ХОТЫН СТАНДАРТЫН БАРИМТ БИЧИГ БИЧГИЙН ЛАВЛАГАА, МЭДЭЭЛЛИЙН САНГ БҮРДҮҮЛЭН ХӨТЛӨХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

- ❖ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 18-26 дугаар тогтоолоор хэлэлцүүлэн батлуулсан 9 бүлгийн 38 хотын стандартын нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх чиглээлээр дараах арга хэмжээг зохион байгуулан ажиллав. Үүнд:
- ❖ Батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг газрын цахим сайтад байршуулав. <https://standard.ub.gov.mn/standards> цахим сайтад байршуулав.
- ❖ Батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг газрын цахим хавтас болох office document z/o/khotiin_standard/i_eelj_38, y_share/khotiin_standard/i_eelj_38 хавтаст байршуулав.
- ❖ Батлагдсан 9 бүлгийн 38 хотын стандартыг бүлэг тус бүрээр нийт 9 дискэд хуулбарлан байгууллагын дотоод мэдээллийн санг баяжуулав.

3.5. ХОТЫН СТАНДАРТ БОЛОВСРУУЛАХ ТАЛААР ЗӨВЛӨН, ТУСЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ

- ❖ 2022 онд Хотын стандартын 9 бүлгийн 15 стандартын төслийг шинээр боловсруулахаар зөвлөн туслах ажиллагааны сонгон шалгаруулалтыг зохион байгуулав. Шалгарсан 15 мэргэжлийн байгуулагатай хамтран ажиллаж анхан болон дундын тайланг хүлээн авч засварлан, тайлангийн хурлыг зохион байгуулж ажиллав.

3.6. ХОТЫН СТАНДАРТЫН ТАЛААРХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

- ❖ Нийслэлийн Засаг даргын 2022 оны A/851 дүгээр захирамжийн Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хот

нийтийн аж ахуйн стандартын салбарын хүрээнд дараах сургалт, арга зүйгээр хангах, зөвлөн туслах арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажиллав. Үүнд:

- Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй 74 төрлийн үйл ажиллагаанд шаардлагатай хотын стандартын талаарх мэдлэг ойлголтыг олгох чиглэлээр худалдаа үйлчилгээний газрын гадна орчны хотын стандартын баримт бичгийн талаарх сэдэвчилсэн сургалтыг ХҮСХ, БОСХ-тэй хамтран нийслэлийн 9 дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхэлж буй 740 иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад 2022.06.10-ны өдрөөс 2022.06.21-ны өдрийг хүртэлх хугацаанд сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулан ажиллав.



- 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран Улаанбаатар хотын нийтийн эзэмшилийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, тохижилт үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг-39, Зам цэвэрлэгээ, үйлчилгээ, хог тээвэр хариуцсан-29, Гэрэлтүүлэг чимэглэлийн арчилгаа үйлчилгээ хариуцсан-15 аж ахуйн нэгж байгууллага болон хот нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ОНӨААТҮГ-ын нийт 80 гаруй ажилтан, албан хаагчдад “Хотын стандартын сэдэвчилсэн” сургалтыг зохион байгуулан ажиллав.
- Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон он дамжиж хийгдэж буй тохижилт, бүтээн байгуулалтын ажилд стандарт, норм, дүрмийн хэрэгжилтийг хангуулж мөрдүүлэх, зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулах удирдамжийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн 9 байршил, Хан-Уул дүүргийн 13 байршил, Баянзүрх дүүргийн 21 байршил, Чингэлтэй дүүргийн 6 байршил, Багануур, Налайх дүүргийн 11 байршилд, нийт 60 байршилд тус тус хийгдэж буй тохижилт бүтээн байгуулалтын ажлуудад батлагдсан стандартыг танилцуулан, арга зүйн зөвлөмжийг өгч ажиллав.
- ❖ 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хотын стандартыг мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1393 дугаар захирамжийн дагуу хотын стандартыг олон нийтэд таниуулан сурталчлахаар 2022 оны 11 дүгээр сарын 11-23-ны өдрийн хооронд хотын стандартын нэгдсэн 5 салбар зөвлөгөөнийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэд олон нийтийн 3100 гаруй төлөөллийг хамруулан зохион байгуулалтад оролцож доорх ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:
 - Зөвлөгөөний урилга, мандат, хулдаасан хэвлэл, стендний загвар боловсруулж хэвлэлийн эх бэлтгэж хэвлүүлсэн.
 - 250 Аж ахуй нэгж байгууллагуудын хаягийг утсаар холбогдон авч цахим урилга илгээсэн

- Хотын стандартын баримт бичгүүдийг иргэд, олон нийтэд танилцуулан тараасан.
- Зөвлөгөөний танхимиын зохион байгуулалтын зургийг боловсруулсан.
- Зочдыг хүлээн авч бүртгэл хийн, мандат тарааж, чиглүүлэн зохион байгуулсан.
- Үдийн цай тараах зохион байгуулалтыг хангаж ажилласан.
- Хэвлэл мэдээлэлд ярилцлага өгсөн.



- ❖ Хотын стандартын талаар иргэд, аж ахуйн нэгжийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх, олон нийтэд сурталчлах чиглэлээр хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтрах ажлын хүрээнд нийт 56 удаа телевизэд ярилцлага өгч ажиллав. Үүнд:
- Монголын Үндэсний Радио Телевиз
 - Mongol HD
 - UBS
 - NTV,
 - Тэнгэр телевизэд,
 - MN25
 - MNC
 - ETV
 - TV5
 - TV9
 - NTV телевизүүдэд,



- ❖ “Худалдаа үйлчилгээний газрын гадна орчин, “Хог хаягдал” бүлгийн хотын стандарт: Худалдаа, үйлчилгээний салбарын үйл ажиллагаа эрхлэгчид болон Нийслэлийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэхэд тусгай зөвшөөрөл шаардахгүй 74 төрлийн үйл ажиллагаанд шаардлагатай хотын стандартын талаар мэдээ, мэдээллийг иргэн, аж ахуй нэгж байгууллага, мэргэжлийн холбоодод танилцуулах хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг нийслэлийн 9 дүүрэгт худалдаа, үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд 2022 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн зохион байгуулж байна. 2022.06.21-ний байдлаар 8 дүүргийн 740 үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуй нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулав.

1. “Зорчигч тээврийн үйлчилгээ” бүлгийн хотын стандарт:

Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд, нийтийн тээврийн хэрэгслийн жолооч нарт “Зорчигч тээврийн үйлчилгээ”-ний хотын стандартыг танилцуулах, сурталчлан таниулах, арга зүйгээр хангах сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 21-ны өдөр Нийтийн тээврийн газартай хамтран зохион байгуулж ажиллав. Сургалтад нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, тээврийн хэрэгслийн жолоочид нийт 240 төлөөлөл хамрагдav.



2. “Иж бүрэн гудамж” бүлгийн хотын стандарт

Төрийн албан хаагчдад хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийн талаар нарийвчилсан мэдлэг олгох зорилгоор хотын стандартын сэдэвчилсэн сургалтыг 2022 оны 03 дүгээр сарын 14-ны өдөр Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газарт танхимаар зохион байгуулав.

Сургалтаар иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэх, улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа төсөл арга хэмжээнд холбогдох стандарт норм дүрмийг мөрдүүлэх, хяналт тавихад стандартын удирдамж арга зүйн 97 баримт бичгийн төрөл, агуулга, хэрэглэх хүрээ, ашиглах арга зүйн талаарх ойлголтыг нийт сургалтад хамрагдсан албан хаагчдад олгов. Сургалтад дүүргийн Захирагчийн ажлын алба, Тохижилтын хэлтсийн мэргэжилтнүүд, 25 хороодын Засаг дарга, зохион байгуулагч нар нийт 50 албан хаагч хамрагdav.

Дээрх сургалтыг зохион байгуулснаар албан хаагчид хөрөнгө оруулалтын ажлыг анх төлөвлөлтийн үе шатнаас стандартыг шаардлагыг хангуулах, шаардлагатай төсөв хөрөнгийг тусгах, зураг төсөл, гүйцэтгэл, ашиглалт гэх мэт бүх үе шатуудад стандартын хэрэгжилтийг хангуулахын ач холбогдлын

- талаар мэдлэг ойлголттой болж цаашдын ажилдаа хотын стандартын бичиг баримтыг хэрэглэх, иргэд олон нийтийг мэдээллээр хангах боломжтой болов.
3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн "Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай" захирамжийн дагуу 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр "Хотын үйлчилгээ" стандартын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, худалдаа, үйлчилгээ эрхлэгчид нийт 400 гаруй төлөөллүүдийг хамруулан үйлчилгээний чанар стандарт, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар мэдээлэл, зөвлөмж өгч ажиллае.
- ❖ Батлагдсан хотын стандартын сэдэвчилсэн сургалтуудыг зохион байгуулах үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөрийг боловсруулж байгууллагын удирдлагаар батлуулсан.
 - ❖ Нийслэлийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн А/851 дүгээр захирамжаар батлагдсан "Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл хангуулах төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангуулахаар холбогдох нутгийн захиргааны байгууллага, албан хаагчдыг мэдээлэл, арга зүйгээр хангаж, сургалт зохион байгуулан ажиллав. **Үүнд:**
 - Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон тохижилт, үйлчилгээ болон аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд хотын стандартын сургалт зохион байгуулах 3 өөр агуулгаар хөтөлбөр боловсруулсан.
 - Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтэс болон Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсүүдтэй хамтарсан уулзалт хийж хуваарь гаргасан.
 - Олон нийтэд шинээр батлагдан гарсан хотын стандартын талаарх ойлголт мэдээлэл хүргэх зорилготой "Хог хаягдлын менежмент" бүлгийн хотын стандартын 5 баримт бичгийн талаар MNC телевизэд 2022.08.30-ны өдөр хуваарийн дагуу ярилцлага өгсөн.
 - Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтран Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт, тохижилт үйлчилгээ, хот нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудад, Нийслэлийн Аялал жуулчлалын газартай хамтран аялал жуулчлал, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудад 09 дүгээр сарын 07,09,16-ны өдрүүдэд зохион байгуулсан сургалтад "Барилгын хог хаягдлын менежмент" "Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент" баримт бичгийг танилцуулсан. Сургалтыг зохион байгуулсан талаар мэдээ бэлтгэж, байгууллагын цахим хуудас, олон нийтийн цахим хуудаст 2022.09.08, 2022.09.19-ний өдрүүдэд нийтэлсэн. Хамтарсан сургалтын талаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны олон нийтийн цахим хуудаст (facebook) 2022.09.16-ны өдөр, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын олон нийтийн цахим хуудаст (facebook) 2022.09.14-ний өдөр тус тус нийтлэгдсэн.
 - Хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, үнэн бодит мэдээлэл хүргэх зорилгоор Худалдаа үйлчилгээний стандартын хэлтэстэй хамтран ажиллаа. Контентийн агуулгад хотын стандартын "Хог хаягдлын менежмент" бүлгээс тохирох хэсгүүдийг оруулах саналыг тусгаж, жүжигчний ярих хэсгийн үгийг бэлдсэн. Түүний дагуу контентын зураг авалтад оролцож, "Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент", "Аюултай хог хаягдлын менежмент"-ийн тухай Хөрс, усны чанарын стандарт хариуцсан мэргэжилтэн товч мэдээлэл өгч зураг авалтад оролцсон.

- Хотын стандартын хүртээмж, хэрэглээ, ашиглах боломж зэргийг тодорхойлох зорилгоор ашиглах санал авах хуудасны загвар боловсруулж батлуулах ажлын хэсэгт орж ажиллан, санал авах маягуудад байгууллагын хэмжээнд бүх хэлтсүүдээс санал авч Маягт1, Маягт2-г байгууллагын удирдлагаар батлуулсан.

3.7. БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИСС

- ❖ Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2022 оны A/861 дүгээр захирамжийн дагуу Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагааг нийт 43 удаагийн батлагдсан хуваарийн дагуу зохион байгуулан ажилласан байна. 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар: а/БА дугаартай **266** барилга байгууламж, Цах дугаартай **437** эрчим хүчний барилга байгууламж, ЗТ дугаартай **198** их засвар шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын дүгнэлтийг тус тус баталгаажуулсан байна. Улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламж, иргэн аж ахуйн нэгж байгууллагын нийт **901** барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авч ажилласан байна.



ДӨРӨВ. ТОГТООЛ ШИЙДВЭР, ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

4.1 ДЭЭД ГАЗРЫН ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

- ❖ 2022 оны байдлаар байгууллагын хэмжээнд хяналтад авсан дээд газраас ирсэн тогтоол шийдвэрүүдээс тус байгууллагатай холбогдолтой заалтуудын биелэлтүүдийг улирал болон сар бүр гаргаж, хагас бүтэн жилийн биелэлтийг Газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэлийн хамт НЗДТГ-ын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Дээд газраас ирсэн тогтоол шийдвэрийн тоо, биелэлтийн хувийн хүснэгтээр үзүүлэв.

№	Шийдвэрийн нэр	Тоо	Дундаж биелэлт
1	Ерөнхийлөгчийн зарлиг	1	90
2	ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл	2	80
3	Монгол Улсын Засгийн газрын тогтоол	6	95
4	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	2	90
5	Монгол Улсын Засгийн Газрын албан даалгавар	2	100

6	Ерөнхий сайдын захирамж	1	100
7	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол	10	90
8	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тэмдэглэл	1	85
Нийт		25	91.25

4.2 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/987 захирамж Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд үйлдвэр, худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах, хүнд суртал, хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн гомдол, маргааныг хууль тогтоомжийн дагуу шуурхай шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах.

- ❖ Шаардлагагүй болсон зөвшөөрөл болон тухайн худалдаа үйлчилгээнд тавигдах шаардлагыг тодорхой болгох ажлын хүрээнд:
- Тусгай зөвшөөрөл шаардлагагүй 9 төрлийн 74 худалдаа үйлчилгээ эрхлэхэд тавигдах 74 шаардлагыг Онлайн бизнес төвийн системд 9 төрлийн 74 үйл ажиллагаа тус бүрээр ангилан байршуулав.
 1. Худалдаа /18 үйл ажиллагаа/
 2. Хоол, үйлдвэрлэл, үйлчилгээ /14/
 3. Ахуйн үйлчилгээ /17/
 4. Зочлох үйлчилгээ /5/
 5. Ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ /8/
 6. Авто үйлчилгээ /6/
 7. Инноваци үйлдвэрлэл /2/
 8. Соёл урлаг /2/
 9. Тоглоомын төв /2/
- ❖ Үндэсний стандарт, Хотын стандартын удирдамж арга зүйн баримт бичгийг Нийслэлийн мэдээ мэдээллийн нэгдсэн портал сайт www.ulaanbaatar.mn цахим системд байршуулах ажлын хүрээнд:
 - Холбогдох үндэсний 76, хотын стандартын 15 баримт бичгийг цахим системд байршуулсан.
- ❖ Дүүрэг, хороодын Засаг дарга, хэсгийн ахлагч нарт сургалт зохион байгуулах ажлын хүрээнд:
 - Тохижилт бүтээн байгуулалтын ажилд стандартын шаардлагыг хангуулах ажлын хүрээнд 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр Баянгол дүүргийн 25 хорооны Засаг дарга, хэсгийн нийт ахлагч нарт “Явган хүний зам талбайн төлөвлөлт, хучилт угсралтад тавигдах шаардлага”, “Хүүхдийн тоглоомын талбай, эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэхэд тавигдах ерөнхий шаардлага” сэдвээр хотын стандартын талаар сургалт зохион байгуулав. Сургалтад нийт 30 хүн хамрагдav.
- ❖ Зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хүрээнд:
 - 2022 оны 03 дугаар сарын 11, 14-ний өдрүүдэд Чингэлтэй, Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн нийт 10 албан хаагчидтай уулзалт зохион байгуулж худалдаа үйлчилгээний үйл ажиллагаа явуулж буй иргэн аж ахуйн нэгжийн одоогийн стандартын нөхцөл байдал, байгууллагуудын нэгдсэн мэдээлэл, мэдээлэл солилцох, судалгааг баяжуулан ирүүлж байх, цаашид хамтран ажиллах тухай хэлэлцэв.

- Үйл ажиллагаа эрхлэгчдийн нэгдсэн мэдээллийг холбогдох нийслэлийн нутгийн захиргааны байгууллага болон дүүргүүдээс нийт 18664 мэдээлэл аван орон зайн мэдээлэлд 744 суурь өгөгдлийг үүсгэн ажиллаж байна.
- ❖ Хотын стандартын баримт бичиг боловсруулах ажлын хүрээнд:
 - 2022 оны 04 дүгээр сарын 28, 05 дугаар сарын 16-ны өдрүүдэд “Монголын явуулын аялал жуулчлал эрхлэгчдийн холбоо”, “Монголын явуулын хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн холбоо”-той уулзалт зохион байгуулан тус салбарын боловсруулсан стандартын төсөлтэй танилцан, боловсруулалтад удирдамж, арга зүйн зөвлөмж өгөх, стандартын хэрэгжилтийг хангуулах, цаашид хамтран ажиллах тухай хэлэлцэв.
 - “Монголын явуулын хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн холбоо”-той хамтран Явуулын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хотын стандартын төсөл боловсруулах, засвар, сайжруулалтын ажил хийгдэж байна.

ТҮЦ-ийн үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагаа явуулах байршлыг тодорхойлох ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар болон бусад нийслэлийн нутгийн захиргааны холбогдох байгууллагууд, дүүргүүдтэй хуваарийн дагуу нэгдсэн уулзалт зохион байгуулахаар төлөвлөж байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1033 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж

- ❖ Тус газраас 2022 онд хотын стандартын 22 бүлгийн 97 стандартыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулах ажлыг төлөвлөсөн. Үүнээс нэгдүгээр ээлжний 9 бүлгийн 38 стандартыг хотын стандартын баримт бичгийг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барих, батлуулах ажлын хэсэг НЗД-ын А/1033 дугаар захирамжаар байгуулагдсан. 2022 оны 03 дугаар сарын 15 -наас 23-ны өдрүүдэд хооронд бэлтгэл ажлыг ханган ажиллав. Үүнд:
- Байгууллага, олон нийтээс ирүүлсэн саналыг нэгтгэн тусгах шаардлагатай саналыг стандартад тусгав.
- Ажлын хэсгийн дэд даргад стандартын баримт бичгийг хянуулан сайжруулалт, засвар хийн хэвлэлийн эх бэлтгэв.
- Байнгын хороо, намуудын бүлгийн хуралд танилцуулж хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлын ханган ажиллав.

2022 оны 03 дугаар сарын 24-ны өдөр НИТХ-д эхний ээлжийн 9 бүлгийн 38 хотын стандартыг өргөн барьж 18-26 дугаар тогтоолоо батлуулж, 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдүүлэхээр болов.



2021 оны А/900 дүгээр Нийслэлийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” захирамж

- ❖ Тус захирамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Хүннүгийн гудамжны 18 байршилд явган хүний замыг өргөтгөхөөр Нийслэлийн Замын хөгжлийн газар, Хот байгуулалт, хөгжлийн газар, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албатай хамтран газар дээр нь үзлэг хийж, хашаа хайсыг буулгуулав.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/361 дүгээр “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах” захирамж,

- ❖ 2022 оны төлөвлөгөөнд газрын чиг үүрэгтэй холбоотой 4 заалт тусгагдсан.

Үүнд:

1. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд барилга байгууламжийн байнгын ашиглалтад оруулах комиссын үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг хангуулах, хяналт тавьж ажиллах:

2022 онд тус газарт 1277 барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт ирсэн.

Үүнд:

- Барилга байгууламж-428
- Цахилгаан хангамж-534
- Засвар, тохижилт-315 байна.

904 иргэн аж, ахуй нэгж байгууллагуудын хүсэлтийг шийдвэрлэн, барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд хүртээмжтэй дэд бүтцийн стандартыг хангуулан ашиглалтад оруулсан байна.

2. UCS 1001-“Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж”, UCS 1001C-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн техникийн зураг төсөл” хотын стандартын баримт бичгийг НИТХ-аар батлуулах:

2022 оны 12 дугаар сарын 25-ний өдөр Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

3. Барилга байгууламж, тохижилт бүтээн байгуулалтын ажлыг ашиглалтад оруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг хангуулах:

Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” А/861 дүгээр захирамж батлагдсан. Комиссын бүрэлдэхүүнд төрийн байгууллага-11, төрийн бус байгууллага-4 хамруулж байна. 2022 оны байдлаар Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагаас төлөөлөл хамруулан 266 барилгыг ашиглалтад оруулж ажиллав.

4. Худалдаа, үйлчилгээний барилга байгууламжийн орох хэсэг, дотоод орчин, ариун цэврийн өрөөнд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тохижилтыг стандартын дагуу хийх, шаардлагатай хэрэглэгдэхүүн, тэмдэг тэмдэглэгээг бий болгох талаар холбогдох журам, стандартад тусгаж, хэрэгжилтийг хангуулж ажиллах:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр UCS1001:А хотын стандартын баримт бичгийг боловсруулсан. Дээрх стандартыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар 2 дугаар ээлжинд батлуулахаар бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Тус хотын стандартад хөгжлийн бэрхшээлтэй иргэнд

зориулсан налуу зам, авто зогсоол, ариун цэврийн өрөөнд тавигдах шаардлага зэргийг тусгасан.

2022 оны А/475 дугаар Нийслэлийн Засаг даргын “Газрын зөрчил арилгах арга хэмжээ авах Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж

- ❖ Ажлын хэсгийн хуралд 2022 оны 04 дүгээр сарын 11-18-ны өдрүүдэд оролцсон. Тус ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 8, 18, 26 дугаар хорооны 17 байршилд газрын зөрчил арилгах ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт газар дээр нь ажиллаж стандартын шаардлага хангахгүй хашаа, хайсыг буулгуулсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/491 дүгээр Нийслэл хотын хэмжээнд замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгсэлтэй холбоотой харилцааг технологийн шийдлийн тусламжтайгаар сайжруулах, зам, тээврийн ухаалаг нэгдсэн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа тооцоог гаргах, техникийн даалгавруудыг нэгтгэх ажлыг хэрэгжүүлэх” захирамж

- ❖ Нийслэлийн цахим хөгжил, мэдээлэл технологийн газар, Нийслэлийн Замын хөгжлийн газар хамтарсан 2 удаагийн хуралд оролцож “RFID” ухаалаг системийг байршуулах 161 цэгийг тодорхойлж, судалгааг хамтран гаргав. “RFID” ухаалаг системийг байршуулах 161 цэгт шон байршуулж байнгын ашиглалтад 2022.12.02-ны өдөр хүлээлгэн өгөв.

2022 оны А/585 дугаар Нийслэлийн Засаг даргын “Хууль, журмын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” захирамж

- ❖ Тус захирамжийн хүрээнд Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүрэгт батлагдсан нийт 376 Байршилаас 208 байршилд хашаа, хайсыг буулгуулж, зөрчлийг арилгуулан хяналт тавин ажилласан.

❖



Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/789 дугаар “Төрийн хэмнэлтийн тухай” захирамж

- ❖ Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүрээнд дараах ажлыг гүйцэтгэв. Үүнд:

- ✓ Тус газрын Орлогч дарга О.Оджаргалыг Газрын даргын 2022 оны Б/23 дугаар тушаалаар орлогч даргын үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.
- ✓ Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байсан Sonata автомашиныг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Төр захиргааны автобаазад хүлээлгэн өгөв.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/851 дүгээр “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” захирамж

- ❖ Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар хотын стандартын 9 бүлгийн 38 стандартыг хэлэлцэн 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдүүлэхээр тогтоосон. Дээрх ажлын хүрээнд “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” нийслэлийн Засаг даргын А/851 дүгээр захирамж гарч хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан.
- ❖ Төлөвлөгөөний биелэлтийг 2022.09.16-ны өдрөөр эцэслэн нутгийн захиргааны байгууллагуудаас хүлээн авч нэгтгэсэн. Нийт 21 байгууллага тайлан ирүүлэхээс 18 байгууллага ирүүлсэн, ирүүлээгүй 3 байгууллага байна.
- ❖ Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл хангуулах төлөвлөгөөнд тусгагдсан 9-н бүлгийн 25 арга хэмжээнээс 22 хангалттай, 3 арга хэмжээ буюу нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтуүлэгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, судлах, стандартын хэм хэмжээг хэрхэн мөрдүүлэхтэй холбоотой суурь судалгаа хийх ажилд хугацаа шаардагдаж байна.
- ❖ Нутгийн захиргааны байгууллагууд 45 арга хэмжээг зохион байгуулсан байна. Үүнд: 2786 иргэн аж ахуйн нэгжид 17 удаагийн сургалт, 1302 удаагийн уулзалт, Хяналт шалгалт зөвлөн туслах чиглэлээр нийт 1631 удаагийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан.
- ❖ Мөн олон нийтэд сурталчилан таниулах чиглэлээр 2 ажил төлөвлөн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 44 удаа мэдээлэл бэлтгэн хүргэсэн.
- ❖ 21 байгууллагаас ирүүлсэн төлөвлөгөөний биелэлт, ажлын тайланг нэгтгэн судалж хэрэгжүүлсэн ажлын явц, үр дүнд дүгнэлт хийхэд хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 17 дугаар хуралд хэлэлцүүлж ажиллав.

Нийслэлийн Засаг даргын А/812 дугаар “Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-ний төслийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах” захирамж

- ❖ Тус захирамжийн дагуу 6 дэд ажлын хэсгийн хэсэг байгуулагдсанаас тус газраас 5 дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав. Үндсэн 11 арга хэмжээ, хамтрагч 4 арга хэмжээг тусгуулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 88 дугаар тогтоолоор “Нийслэлийн хөгжлийн 2023 оны төлөвлөгөө”-г батлуулахад хамтран ажиллав.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/986 дугаар “Дэд ажлын хэсэг байгуулах тухай” захирамж

- ❖ Тус ажлын хэсгийн хуралд 3 удаа оролцож, холбогдох судалгаа хийж, мэдээллийг ажлын хэсэгт хүргүүлэв. Үүнд:
- Ашиглалтад орсон сургууль цэцэрлэгийн мэдээлэл./49/
- Ашиглалтад орсон орон сууцны мэдээлэл /259/

- Он дамжин болон шинээр ашиглалтад орж буй сургууль, цэцэрлэгийн мэдээлэл /22/ Мөн цэцэрлэгийн гадна орчны стандарт шаардлагын талаар мэдээлэл өгч ажиллав.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1121 дүгээр “Улаанбаатар хотын амьдралын чанарыг сайжруулах” захирамж

- ❖ Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Улаанбаатар хотын амьдралын чанарын стандартын хуулийн төсөлд оруулах Хот нийтийн аж ахуйн салбарт тулгамдаж буй асуудал, Байгаль орчны салбарын хууль, эрхзүй стандартын зохицуулалт, Худалдаа үйлчилгээний салбарт мөрдөгдж байгаа стандарт, норм дүрмийн санал гэхchlэн сэвдийн саналыг нийт хэлтсүүдээс авч нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын, Хууль эрхзүйн хэлтэст 01/456 тоот албан бичгээр хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1305 дугаар “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамж

- ❖ Тус ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хуралдаж, 12 бүлгийн 29 стандартыг 2022 онд багтаан Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлж, батлуулах төлөвлөгөөг боловсруулж 7 арга хэмжээ тусгаж ажиллав. Төлөвлөгөөний дагуу хотын стандартын төслийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдэд танилцуулга хийх, хэлэлцүүлгийг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар 2022 оны 12 сард хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангуулан ажиллаж байна.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1372 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлын хэсэг” захирамж

- ❖ Нийслэлийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/1372 дугаар захирамжаар Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх төлөвлөгөөний төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэгт хэлтсийн дарга Н.Билэгсайхан томилогдон ажиллаж байна. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд санал боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 01/611 дугаар албан бичгээр Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэв.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1393 дугаар “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн” зохион байгуулах тухай захирамж

- ❖ Нийслэлийн Засаг даргын А/1393 дугаар захирамжаар “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ийг зохион байгуулах удирдамж батлагдсан. Үүний дагуу Хотын стандартын тогтолцоо, Хотын соёл, Хотын үйлчилгээ, Иргэдийн ая тухтай орчин, Барилгын аюулгүй орчин сэдэвт нийт 5 удаагийн зөвлөгөөний хөтөлбөр боловсруулж бэлтгэл хангуулан 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 23-ны өдрүүдэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуйн нэгжүүдийн 3100 оролцогчийг хамруулан хотын стандартыг сурталчлан таниулж ажиллав.



Нийслэлийн Засаг даргын 2022 оны

A/1413 дугаар “Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага шинэчлэх” захирамж

- ❖ Тус захирамжийн ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу MNS 5283 : 2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага- батлагдсан стандартад өөрчлөлт оруулах саналыг 2022 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор хүргүүлэхээр төлөвлгөөний дагуу ажиллаж байна. Мөн 2023.02.30-ны өдрийн дотор MNS 5283 : 2022 Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгө, аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн тэмдэгт тавих ерөнхий шаардлага- баримт бичгийн хаягийн загварыг гарган холбогдох байгууллагуудаас санал авч ажиллахаар төлөвлөн ажиллаж байна.

Налайх дүүргийн Засаг даргын 2022 оны A/147 дугаар “Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврын дагуу Налайх дүүргийн Засаг даргын хяналт шалгалт хийх ажлын хэсэг” захирамж

- ❖ Горхи-Тэрэлжийн нутаг дэвсгэрт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 108 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2022.06.22-30-ны өдрүүдэд ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт хяналт тавьж, зөвлөн тусалж, арга зүйгээр ханган ажилласан.

4.3 НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТ

Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурал, шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэн нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авах, гүйцэтгэлийг тухай бүр тайлагнах ажлын хэрэгжилт

- ❖ Тус газарт 2022 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын 4 удаагийн Зөвлөлийн хурлаар нийт 5 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд үүрэг ту бүрд нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээг зохион байгуулан гүйцэтгэлийг тухай бүр тайлагнаж ажиллав.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх, гүйцэтгэлийг тогтмол тайлагнах ажлын хэрэгжилт

- ❖ Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанаас хот нийтийн аж ахуйн чиглэлээр өгөгдсөн нийт 4 үүрэг даалгавар өгөгдсөн бөгөөд биелэлтийг тухай бүр хангуулан UBZAA2020@gmail.com цахим хаягаар хүргүүлэв.

Хариуцсан чиг үүрэгтэй холбоотой асуудлаар Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулга хийх, асуудал шийдвэрлүүлэх ажлын хэрэгжилт

- ❖ 2022 оны байдлаар газрын хариуцсан чиг үүргийн хүрээнд дараах асуудлуудыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Үүнд:
 - ✓ Хотын стандартын 22 бүлгийн 97 нэр төрлийн баримт бичгийг боловсруулах зорилтын хүрээнд 1 дүгээр ээлжийн 9 бүлгийн 38 нэр төрлийн баримт бичгийг батлуулах бэлтгэл ажлыг хангулан 2022 оны 02 дугаар сарын 17-ны өдөр;
 - ✓ Нийслэлийн нутгийн захирагааны 97 байгууллагаас салбарын үйл ажиллагаанд дагаж, мөрддөг стандарт, техникийн зохицуулалт, норм, дүрмийн судалгаа авсан танилцуулга 2022 оны 07 сарын 06-ны өдөр;
 - ✓ “Барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах үйл ажиллагаа”-ны тоон мэдээ, мэдээлэл бүхий танилцуулга 08 дугаар сарын 26-ны өдөр;
 - ✓ Хотын стандартыг дагаж мөрдүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Хотын стандартыг мөрдүүлэх бэлтгэл арга хэмжээний төлөвлөгөөг батлах тухай” А/851 дүгээр захирамж батлуулсан. Тус төлөвлөгөөнд 11 зорилтын 25 арга хэмжээг тусгасан. Захирамжийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын танилцуулга 10 дугаар сарын 18-ны өдөр тус тус Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулав.
 - ✓ Хотын стандартыг мөрдүүлж эхэлсэнтэй холбогдуулан нэгдсэн зөвлөгөөн зохион байгуулах удирдамж, төлөвлөгөөний төсөл боловсруулж танилцуулав.

Байгууллагын тухайн жилийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх, албан хаагчдыг ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслээр хангах.

- ❖ Байгууллагын тухайн жилийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөөг боловсруулан албан хаагчдад барилгын аюулгүй байдлын талаар улирал бүр заавар зөвлөмж өгч ажиллав.
- ❖ Барилгын комисст ажилладаг албан хаагчдын ажлын тусгай хэрэгцээнд зориулж 12 ширхэг өвлийн хувцасны захиалга өгч хүлээлгэн өгөв.


4.4 НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ КОМИССООС ӨГӨХ ҮҮРЭГ ДААЛГАВРЫГ ХЭРЭГЖИЛТ

4.4.1 Сайжруулсан түлшний хэрэглээ, борлуулалт, түгээлтийн үйл ажиллагаанд хяналт тавих, иргэд, аж ахуйн нэгжид зөвлөмж, заавар өгч ажиллах ажлын хүрээнд

- ❖ Нийслэлийн Засаг даргын “Ажлын хэсэг байгуулах тухай” 2021 оны А/779 дүгээр захирамжийн хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны агаарын чанаарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс зөвшөөрөлгүй тулж байгаа эсэхэд хяналт тавих, мэргэжил арга зүйн зөвлөгөө үзүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагуудын хамтарсан үзлэг хийж нийт 49 өрхөд зуухны битүүмжлэл, түлшний хэрэглээ, угаарын хийнээс урьдчилан сэргийлэх, сайжруулсан шахмал түлшний галлагаа болон яндан зуухны аюулгүй байдлыг хангах талаар зөвлөмж өгөв.
- ❖ Нийслэлийн Онцгой комиссоос 2022 онд баталсан “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж, мэдээлэл өгч ажиллах байгууллага, албан тушаалтны хуваарь”-ийн дагуу Сүхбаатар дүүргийн 15,

17 дугаар хороодын Зохион байгуулагчдаас сайжруулсан шахмал түлшний борлуулалт, нөөцлөлтийн мэдээг авч нэгтгэн, нийт 12 удаагийн мэдээг Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газрын Хяналт зохицуулалтын ажилтанд ERP цахим системээр хүргүүлсэн.

- ❖ Нийслэлийн Засаг даргын “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 2022 оны A/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг 2022 оны 01/647 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.
- ❖ Сайжруулсан түлшний борлуулалт, түгээлт, нөөцийн мэдээлэл болон угаарын хий мэдрэгчийг шалгах үүрэг бүхий албан хаагчдын хуваарийг боловсруулж батлуулан. хуваарийн дагуу Сүхбаатар дүүргийн 15,17 дугаар хороодод ажиллав.



4.4.2 Цар тахлын халдвартыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх хүрээнд өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж биелэлтийг тухай бүр холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх ажлын хүрээнд.

- ❖ Нийслэлийн Онцгой комиссоос цар тахлын халдвартыг бууруулах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан ажиллав. Үүнд:
- ✓ Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилт, айл өрхүүдэд сайжруулсан түлш нийлүүлэх, түгээх үйл ажиллагааны хэрэгжилтийг хангуулах хяналт тавих ажлын хүрээнд 2022 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны айл өрхүүдэд сайжруулсан шахмал түлш болон нүүрсний хэрэглээ, зуух пийшингийн бүрэн бүтэн байдалд шалгалт хийж хяналт тавьж ажилласан.
- ✓ Коронавирусээс урьдчилан сэргийлэх тарилгын 4 дүгээр тунд 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр албан хаагчдыг хамруулав.
- ✓ Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөнийг зохион байгуулах хүрээнд оролцогчдыг ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн амны хаалт тарааж гар ариутгагчаар үйлчилсэн.
- ✓ Албан хаагчдын компьютер тоног төхөөрөмж, програм хангамжийн хэвийн ажиллагааг хангах, шаардлагатай үед цахимаар ажиллах нөхцлийг бүрдүүлэх чиг үүргийн хүрээнд албан хаагчдын компьютер, тоног төхөөрөмж, сүлжээний дараах тохиргоо, зохицуулалтыг хийж гүйцэтгэв.

ТАВ. ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1 ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ

5.1.1 Үйл ажиллагааны ил тод байдал

- ❖ “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханггуулж ажиллалаа. Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасны дагуу байгууллагын төсөв, зардлын санхүүжилт, хүний нөөц, орон тооны өөрчлөлтийн мэдээлэл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдүүлэг, холбогдох тайлбарыг <https://shilendans.gov.mn/> цахим хуудсанд сар бүр тогтмол нийтэлж “Шилэн дансны тухай хууль”-ийн хэрэгжилтийг ханггуулан ил тод, нээлттэй байдлыг ханггуулан ажиллав.
- ❖ Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд дараах төрлийн мэдээллийг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэв.

Үүнд:

- Цаг үеийн мэдээ – 19
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарь – 31
- Барилга байгууламжийн их засвар шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарь – 23
- Зарлагдсан сул орон тооны мэдээлэл – 3
- Тендерийн урилга – 29
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам – 3
- Газрын даргын тушаал – 49
- Санал авч буй хотын стандартын төсөл – 2
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллах үе шат, дараалал – 3
- Санал авч буй журмын төсөл – 1
- Хотын стандартын зөвлөгөөний мэдээлэл – 1
- Хотын стандарт боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөлд санал авах ажилд зориулан 2 төрлийн баннер хийж байгууллагын фэйсбууц хуудас болон нийслэлийн мэдээ, мэдээллийн нэгдсэн портал сайт www.ulaanbaatar.mn -д байршуулав.

5.1.2 Төсөв, санхүүгийн ил тод байдал

- ❖ 2022 оны Байгууллагын батлагдсан төсвийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өр авлага үүсгэхгүй ажиллах, холбогдох тайлан мэдээг тогтоосон хугацаанд нь үнэн зөв тайлагнаж ажиллаж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар байгууллагын батлагдсан төсөв 1,342,973,700 төгрөг байна. Үүнээс жилийн эцсийн гүйцэтгэл 1,240,747,279 төгрөг байна. Нийт батлагдсан төсвийн хүрээнд 92,3%-ийн гүйцэтгэлтэй ажиллаж байна. Төсвийн гүйцэтгэлийн 40.7%-ийг цалингийн сан эзэлж байна. Энэ нь орон тоо дутуу төрийн хэмнэлтийн хуулийн дагуу орлогч даргын орон тоог бууруулж ажилласантай холбоотой. Төрийн хэмнэлтийн тухай хууль Монгол Улсын засгийн газрын 388 дугаар тогтоолын дагуу бичиг хэрэг, тээвэр шатахууны зардлаас тус бүр 10 хувийн хэмнэлт гарган ажилласан.

5.2 ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ

Хотын стандартыг тогтолцоог хөгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, туршлага бүхий хүний нөөцийг бүрдүүлж үйл ажиллагааны жигд тогтвортой байдлыг хангуулах зорилго тавин хүний нөөцийн чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэв.

5.2.1 Газрын дүрэмд тусгасан чиг үүргийн дагуу газрын бүтэц, орон тоог баталж, түүнд зохих мэдлэг, туршлага, мэргэжил бүхий шаардлага хангасан хүний нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд:

- ❖ Тус газрын дүрэм Нийслэлийн Засаг даргын А/112 дугаар захирамжаар 2022 оны 01-р сарын 31-ний өдөр батлагдсан. Батлагдан дүрэмд нийцүүлэн байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын жагсаалт, ангилал зэрэглэлийг А/01 дүгээр тушаалаар батлуулж, хэлтсүүдийн чиг үүргийг дахин хувиарлан хэлтсүүдийн үйл ажиллагааны дүрмийг газрын даргын А/02 дугаар тушаалаар шинэчилсэн. Шинэчилсэн дүрэмд нийцүүлэн газрын албан тушаалын тодорхойлолтыг хэлтэс, нэгжүүдтэй хамтран боловсруулж Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 330 дугаар тогтоолоор батлах зөвшөөрлийг авч газрын даргын А/29 дүгээр тушаалаар Төрийн захиргааны 36 албан тушаалын тодорхойлолтыг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан.
- ❖ Албан тушаалын тодорхойлолт батлагдсаны дагуу 2022 оны 6 дугаар сард 30, 10 дугаар сард 6, 11 дүгээр сард 2 албан тушаалын сул орон тоонд сонгон шалгаруулалт зохион байгуулах захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Захиалгын дагуу 25 албан хаагч тусгай шалгалтад хамрагдаж албан тушаалдаа жинхлэн томилогдож, 13 албан тушаалын сул орон тоо нөхөгдөөгүй байна.

5.2.2 Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу албан хаагчдыг чөлөөлөх, чөлөө олгох сэлгэн ажиллуулах, зэрэг арга хэмжээг авч байгууллагын үйл ажиллагааны жигд тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд:

- ❖ Нийслэлийн бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу албан хаагчдыг чөлөөлж, томилсон тухай газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн Б/05, Б/06, 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн Б/23, Б/25 дугаар тушаалуудыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулж батлуулав. Холбогдох тайлан мэдээг Нийслэлийн Засаг даргын тамгын газарт 2, 5 дугаар сард хүргүүлсэн. 2022 оны жилийн эцсийн байдлаар ажлаас чөлөөлөгдсөн 7, цалинтай, цалингүй чөлөө олгосон 2, сэлгэн ажиллуулсан албан хаагч байхгүй байна.

5.2.3 Тогтсон хуваарийн дагуу албан хаагчдын дунд “мэдээллийн цаг” арга хэмжээг зохион байгуулж ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээллийг солилцох, танин мэдэхүйн ач холбогдол бүхий арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд:


- ❖ Газрын нийт албан хаагчдыг мэдээллээр хангах, мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, ур чадварыг хөгжүүлэх зорилготой 2022 онд зохион байгуулан хэрэгжүүлэх “Мэдээллийн цагийн хуваарь”-ийг 2022 оны 02 дугаар сарын 24-ний өдөр газрын даргаар батлуулсан. Уг хуваарьт байгууллагын дэргэдэх орон тооны бус 5 зөвлөл, 5 хэлтсээс хариуцан зохион байгуулахаар төлөвлөснөөс 5 арга хэмжээ зохион байгуулагдаж, бусад арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх боломжгүй байв.

5.2.4 Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан үндэслэлийн дагуу албан хаагчдыг ерөнхий болон тусгай шалгалтад хамруулах, албан тушаалын тодорхойлолтыг батлуулах арга хэмжээг авч байгууллагын үйл ажиллагааны жигд тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд:

- ❖ Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 330 дугаар тогтоолоор албан тушаалын тодорхойлолт батлах зөвшөөрлийг авч газрын даргын А/29 дүгээр тушаалаар тус газрын Төрийн захиргааны 36 албан тушаалын тодорхойлолтыг 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан.
- ❖ Албан тушаалын тодорхойлолт батлагдсан даруй байгууллагын үйл ажиллагааны жигд, тасралтгүй хэвийн үйл ажиллагааг хангуулах хүрээнд хэлтсүүдэд нэн шаардлагатай байгаа сүл орон тоог нөхөн бүрдүүлэхээр Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд 2022 оны 6, 10, 11 дүгээр саруудад нийт 38 албан тушаалын сүл орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсний үр дүнд Төрийн захиргааны албан тушаалын орон тооны 87,5 хувь нь Төрийн албаны хуулийн дагуу албан тушаалдаа жинхлэн томилогдсон.

5.2.5 Албан хаагчдын ажлын нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгсэл, бичиг хэргийн материал, дутагдалтай байгаа компьютер, тоног төхөөрөмж, албан тасалгааны тавилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдан авах ажлын хүрээнд:

- ❖ Албан хаагчдын ажлын байрны ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор 2022 оны байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгэв.
- ❖ Хэлтэс тус бүрт принтерийн хор, бичгийн цаас болон хэрэгцээт бичиг хэргийн материалыг Газрын даргын 2022 оны “Хөрөнгө гаргах тухай” А/18 дугаар тушаалын дагуу худалдан авав.
- ❖ Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1059 дүгээр захирамжаар тус газрын нэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан байгууллагын гадна хаягийг шинэчлэв.
- ❖ Албан тасалгааны тавилга эвдэрсэнтэй холбогдуулан 50 ширхэг сандлын дугуй худалдан авч 10 сандлын дугуйг солиулав.
- ❖ Албан хаагчдад 12 ширхэг өвлүүн ажлын хувцасны захиалга өгч холбогдох 6 албан хаагчдад хүлээлгэн өгөв.



- ❖ Хангарьд ордны 12 давхарт байрлах албан тасалгааны цонхонд хөшиг хийлгэж, 4 гэрэл солиулав.
- ❖ Байгууллагын стажерс автомашиныг оношлогоонд оруулах, бусад хэрэгцээт үйлчилгээг үзүүлэв.
- ❖ Албан хэрэгцээнд шаардлагатай бинзэн талоны бүртгэл хөтлөн, тухай бүр шаардах хуудсаар олгож бурдлийг хангуулав.

5.2.6 Байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх болон хөдөлмөр эрхлэлттэй холбоотой аливаа маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх, шүүхийн маргаантай холбоотой мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хүргүүлэх ажлын хүрээнд:

- ❖ 2022 оны жилийн эцсийн байдлаар ажилтан, албан хаагчийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой маргаан үүсээгүй байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэн тус газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/16 дугаар тушаалаар шинэчилэн боловсруулж батлуулан байгууллагадаа мөрдлөгө болгон ажиллаж байна.

5.2.7 Хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд:

Байгууллагын “Хүний нөөцийг чадавхижуулах, тогтвортой суурьшилтай ажиллуулах 2022 оны төлөвлөгөө”-нд 12 ажил, арга хэмжээг төлөвлөн боловсруулж газрын даргаар 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдөр батлуулан хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан. Үүнд :

- ✓ Албан хаагчдын ажилласан жил, мэргэжил, ур чадварыг үндэслэн нэмэгдэл олгуулах санал боловсруулж газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар 15 албан хаагчийн шатлалыг ахиулан олгуулсан.
- ✓ Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 192, 194 дүгээр тогтооолоор Төрийн захиргааны албан хаагчдын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орсны дагуу албан хаагчдын ангилал зэрэглэлийг шинэчлэн боловсруулж газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн “Үндсэн цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоох тухай” А/31 дүгээр тушаалаар 39 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоож цалинг нэмэгдлийн дагуу олгуулсан.
- ✓ Төрийн захиргааны 12 албан хаагчийн зэрэг дэвийг шинээр болон ахиулан олгуулах саналыг боловсруулж 2022 оны 2 дугаар сард Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/641 дүгээр захирамжаар 11 албан хаагчид зэргийн нэмэгдэл олгуулав.
- ✓ Геодезийн мэргэшсэн зэрэг горилсон 1 албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгуулав.
- ✓ Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөх болзол шаардлага хангасан 7 албан хаагчийг тангараг өргүүлсэн.
- ✓ Төрийн дээд шагналд -1, Нийслэлийн Засаг даргын шагналд 1, Нийслэлийн Засаг даргын шагналд-7, Монголын залуучуудын холбооны шагналд-4, нийт 15 албан хаагчийг тодорхойлж шагнаж урамшуулсан.



- ✓ Албан хаагчид гэр бүлийг дэмжих, шинэ төрсөн хүүхэд, ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн байдал зэрэгт тэтгэмж олгуулсан.
- ✓ Албан хаагчдын орон сууцны нөхцөлийн судалгааг 2022 оны 4 дүгээр сард, Ажлын байрны таатай орчныг тодорхойлох, сэтгэл, ханамжийн санал, асуулга, судалгааг 2022 оны 9 дүгээр сард байгууллагын 40 албан хаагчаас авч, үр дүнг газрын удирдлагад танилцуулсан.
- ✓ Байгууллагын хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой 40 гаруй тайлан, мэдээ, судалгааг тухай бүр холбогдох дээд шатны байгууллагад тайлاغнасан.
- ✓ Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх хүрээнд Нийслэлийн засаг даргын Тамгын газар Хүний нөөцийн хөгжлийн төвийн төлөвлөгөөт 15 төрлийн сургалтад давхардсан тоогоор 43 албан хаагчийг тус тус танхимаар болон цахимаар хамруулсан.
- ✓ Удирдлагын академийн мэргэшүүлэх 2 төрлийн сургалтад хувийн зардлаар нь 5 албан хаагчийг хамруулсан.
- ✓ Албан хаагчдын гэр бүл, эрүүл мэндийн дархлаанд зориулан гадны сургагч багш урьж 2022 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Гэр бүлийн харилцаа, 2022 оны 09 сарын 27-ны өдөр Сэтгэл зүйн эрүүл мэнд сэдвээр сургалт авч 38 албан хаагчийг хамруулсан.



- ✓ Ажилд шинээр томилогдсон 13 албан хаагчийг харьяа дүүргийн эмнэлэгт эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулсны үндсэн дээр ажилд томилсон.
- ✓ Албан хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх хүрээнд “Илүүдэл жингүй, эрүүл монгол” хөтөлбөр, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын тэмцээний хэрэгжилтийг Спорт хамтлагтай хамтран зохион байгуулсан.


5.3 ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ

5.3.1 Өргөдөл гомдолын шийдвэрлэлт

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”-ын 4.4, Нийслэлийн Засаг даргын 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1049 дүгээр захирамжаар баталсан “Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-н хэрэгжүүлэн ажиллалаа. Албан бичиг, өргөдөл гомдлын мэдээллийг доорх хүснэгтээр харуулав.

№	Албан бичиг				Өргөдөл гомдол		
	Ирсэн	Шийдвэрлэсэн	Судлаж буй	Явуулсан	Ирсэн	Шийдвэрлэсэн	Судлаж буй
1	2373	2325	48	719	224	224	0

Монгол улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан 214 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжийг гаргасан. Тус захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын А/1538 дугаартай захирамжаар Нийслэлийн харьяа агентлагууд Иргэдээс төрийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлыг шуурхай шийдвэрлэхээр захирамжилсаны дагуу Газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн гаргасан “Өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/52 дугаар тушаалаар 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хооронд газрын шуурхай штаб байгуулан ажилласан. Иргэдээс гаргасан өргөдөл гомдоор шуурхай ажиллан, шийдвэрлэлтийг өдөр бүр Засаг даргын тамгын газарт хүргүүлэн ажиллав.



5.3.2 Албан бичиг, архивын үйл ажиллагааны хэрэгжилт


5.3.2.1 2021 онд байгууллагын хэмжээнд хөтлөгдсөн бүх бичиг баримтуудыг хэрэг бүрдүүлэн хадгаламжийн нэгж үүсгэх, Хөтлөх хэргийн

нэрийн жагсаалтын дагуу архивын нөхөн бүрдүүлэлт хийх, архивт хүлээн авах ажлын хүрээнд:

- ❖ Архивын тухай хууль, Төрийн архивын байнгын хадгалалтад баримт шилжүүлэх журмыг мөрдлөг болгон 2021 оны хөтлөх хэргийн нэrsийн жагсаалтын дагуу 208 хадгаламжийн нэгжийг хэлтсүүдээс хүлээн авч байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлт хийв.

5.3.2.2 Байгууллагын архивын нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан 2021 оны хадгаламжийн нэгжүүдэд Баримт бичгийн нягтлан шалгалт хийх, ангилан төрөлжүүлэх байнга хадгалах, түр хадгалах, 70 жил хадгалах, тусгай төрөл, зэргээр ангилан төрөлжүүлж данс бүртгэл үйлдэх ажлын хүрээнд:

- ❖ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2021 онд хөтлөгдөх 54 хэргийн цаасан суурьтай 208 хадгаламжийн нэгжийн баримт бичгийн бүрдэл, стандартыг шалгаж хуваарийн дагуу хүлээн авав. Үүнд:
 - Байнга хадгалах 18166 хуудас 105 боть
 - Түр хадгалах 13351 хуудас 96 боть
 - 70 жил хадгалах 1142 хуудас 7 боть тус тус хүлээн авсан баримтуудын хадгалах хугацааг тогтоох, тэдгээрийг байнгын хадгалалтанд сонгох зорилгоор баримт бүрийн үнэ цэнийг нягтлан шалгаж, эрдэм шинжилгээ техник боловсруулалтыг хийж архивын сан хөмрөгт байршуулав.



5.3.2.3 Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын санал авах, боловсруулах, батлуулах, хуваарь гаргах

- ❖ Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад бүх хэлтсүүдээс санал авч нэгтгэн, 2022 онд хөтлөгдөх Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт шинэчлэн боловсруулж, Нийслэлийн Архивын газрын Мэргэжлийн удирдлагын хэлтсээр хянуулан байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 02 дугаар хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

5.3.2.4 ERP системд албан хаагчдын мэдээллийг оруулах, албан хэрэг хөтлөлт, албан бичиг боловсруулах үйл ажиллагааг цахимаар гүйцэтгэж хэвшүүлэх, хяналт тавих ажлын хүрээнд:

- ❖ Нутгийн захиргааны байгууллагын дотоод удирдлагын системд нийслэлийн бүтэц, зохион байгуулалтаар байгууллагын бүтэц, орон тоонд орсон өөрчлөлтүүд болон шинээр ажилд орсон, гарсан албан хаагчдын бүртгэлийг тухай бүр бүрэн гүйцэд оруулан шинэчлэн бүртгэж, холбогдох эрхийн тохиргоог хийж өдөр тутмын хэвийн үйл ажиллагааг хангуулав. 2022 оны

жилийн эцсийн байдлаар томилж, чөлөөлөгдсөн 55 албан хаагчийн мэдээлэл, 40 албан хаагчийн ээлжийн амралт, цаг бүртгэл, цагийн хүсэлт 998, сургалт хөгжил цэсэнд тус тус тогтмол баяжуулав.

- ❖ Албан хэрэг хөтлөлт, өргөдөл, гомдлын системийг байгууллагын хэмжээнд нийт албан хаагчдаар бүрэн гүйцэд ашиглуулах ажлыг амжилттай нэвтрүүлэн, баримт боловсруулалтын ажлыг гүйцэд ашиглан ажиллаж байна.

5.3.3 Байгууллага дахь зөвлөлүүдийн үйл ажиллагааны хэрэгжилт Залуучуудын зөвлөл:

- ❖ Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжих чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр, эрх, үүргийг хэрэгжүүлэх зорилготой байгуулагдсан “Залуучуудын зөвлөл”-өөс батлагдсан төлөвлөгөөний дагуу нийт албан хаагчдад чөлөөтэй үзэл бодлоо илэрхийлэх “Чөлөөт индэр” самбарын загварыг боловсруулан батлуулав.



Чөлөөт индэр самбарын загвар

Биеийн тамир спортын зөвлөл:

- ❖ Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.1 дэх заалт “Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, иргэн, гэр бүл, байгууллага, хамт олныг нийгмийн олон талт хамтын ажиллагаанд тулгуурлан эрүүл амьдрах хэв маяг төлөвшүүлэх, дасгал хөдөлгөөнийг өдөр бүр хийж, илүүдэл жингүй эртэч, идэвхтэй иргэнийг бий болгох” зорилтын хүрээнд байгууллагын биеийн тамир, спортын хамтлагаас “Илүүдэл жингүй эртэч монгол” аянд Хан-Уул дүүргийн Засаг Даргын Тамгын газраас баталсан хуваарийн дагуу өглөөний дасгалыг зохион байгуулж нийт албан хаагчид амжилттай хамрагдав.



“Илүүдэл жингүй эртэч Монгол”

- ❖ Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын ажилтан, албан хаагчдын “Хаврын баяр” биеийн тамир, спорт өдөрлөгт бүжгийн тэмцээн, зургийн уралдаанд амжилттай оролцов.



“Хаврын баяр” өдөрлөг

- ❖ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иргэдийн биеийн тамир, спортоор хичээллэх хүсэл, сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбаатар Марафонд нэгдэцгээ” нийслэлийн Засаг даргын нэрэмжит цом аялан явах хуваарийн дагуу Хот байгуулалт, хөгжлийн газраас шилжин ирснийг Хотын стандарт, хяналтын газар хүлээн авч аянд нэгдэв.



Эцэг эхийн зөвлөл:

- ❖ “Эцэг эхийн зөвлөл” 2022 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу нийт 3 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан. Үүнд:
 - ✓ Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас хэрэгжүүлж буй “Нэгдүгээрт шалга” аяны хүрээнд удирдамжид заагдсан 4 чиглэлийн үйл ажиллагаанд байгууллагын нийт 36 албан хаагчдаас хүүхэдтэй 27 албан хаагчдыг судалгаанд идэвхтэй хамруулав.


Байгууллагын албан хаагчдаас авах судалгааны форм үүсгэсэн байдал

- “Гэр орчны аюулгүй байдлын үнэлгээ”-г гүүгл формоор нийт 27 албан хаагч бөглөн илгээсэн.
- “Амьдарч буй орчин, оршин суугаа газрын аюулгүй байдлын үнэлгээ”-г 20 албан хаагч үнэлж, дүгнэсэн.
- “Хүүхдийнхээ гэрээс сургууль, цэцэрлэг хүрэх орчны аюулгүй байдлын үнэлгээ”-г 25 албан хаагч үнэлж, дүгнэсэн.
- “Нийслэлийн төр захиргааны байгууллагууд өөрийн байгууллагад хамаарах гадаад болон дотоод орчныг үнэлэх”,

ХҮХДЭД ЭЭЛТЭЙ ОРЧИН БҮРДҮҮЛЭХ ЗОРИЛГООР
ЗОХИОН БАЙГУУЛСАН ЭРСДЭЛЭЭС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЛЭХ **"НЭГДҮГЭЭРТ ШАЛГА"** АЯНД
НЭГДЭЖ АЖИЛЛАСАН ТА БОЛОН ТАНАЙ ХАМТ ОЛОНД
НИЙСЛЭЛИЙН 562,955 ХҮХДИЙН
ӨМНӨӨС ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЬЕ.

Аянд оролцож “Нэгдүгээрт шалга” аяны Талархал авав

Хүүхдийг орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх “Нэгдүгээрт шалга” арга хэмжээг зохион байгуулан ажилласан тухай тайлан гаргаж Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын холбогдох албан хаагчийн цахим хаягт 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр хүргүүлсэн.



Зураг 4. Хүргүүлсэн тайлан

- ✓ Байгууллагын албан хаагчдын хүүхдийн судалгааг гаргаж “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-т зориулж хүүхэд бүрийн нас, хүйсийн онцлогт тохирсон бэлгийн судалгаа хийж, 0-6 насны 31 хүүхэд (хүү-11, охин-20), 7-12 насны 16 хүүхэд (хүү-8, охин-8), 13-17 насны 7 хүүхэд (хүү-5, охин-2) нийт 54 хүүхдэд бэлэг олгуулав.

- ✓ Сургуулийн нийгмийн ажилтаны нийгэмлэгийн тэргүүн Б.Мөнхжаргал лектортой хамтран "Хүүхдийн хүмүүжилд эцэг эхийн үүрэг, гэр бүлийн зэрэг харилцаа" сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулж, байгууллагын албан хаагчдыг хамруулав.



Сургалтад хамрагдаж буй байдал

5.4 ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ

Төрийн байгууллагын дотоод засаглалын үйл ажиллагааг тогтмол сайжруулах, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх ажлын хүрээнд:

5.4.1 Төрийн албаны тухай хууль болон байгууллагын дотоод дүрэм, журмыг удаа дараа зөрчсөн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах

- ❖ 2022 оны байдлаар байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хяналтын шар хуудсыг 1 албан хаагчид олгон хяналтын хуудас олгосон тухай бүртгэлийг хөтлөв. Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомж зөрчсөн албан хаагч байхгүй болно. Нийт албан хаагчид сахилгын зөрчил дутагдал гаргалгүй ажиллав.

5.4.2 Ёс зүйн дотоод журмаа шинэчлэн боловсруулж батлуулах

- ❖ Газрын хэмжээнд дагаж мөрдөх “Ёс зүйн дотоод дүрэм”-ийг шинэчлэн боловсруулан Газрын даргын 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн “Ёс зүйн дотоод дүрэм шинэчлэн батлах тухай” А/10 дугаар тушаалаар батлуулан дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

5.4.3 Чанарын удирдлагын тогтолцооны дотоод аудитын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу зохион байгуулах, үр дүнд илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах

- ❖ Газрын даргын 2022 оны “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай” А/40 дүгээр тушаал дотоод хяналт, шалгалт зохион байгуулах тухай удирдамж, хуваарийн дагуу 2022 оны 09 дүгээр сарын 08-26-ны өдрийн хооронд газрын нийт 6 хэлтсийн үйл ажиллагаанд 5 ажлын хэсэг, нийт 13 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр дотоод хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллав. Дотоод хяналт шалгалтыг 4 үндсэн чиглэл 23 шалгуур үзүүлэлтийн дагуу зохион байгуулан илэрсэн зөрчил, засаж сайжруулах арга хэмжээний талаар санал гарган нийт 40 зөвлөмжийг хэлтсүүдэд өгч ажиллав. Зөвлөмжийн дагуу “Ажил сайжруулах удирдамж батлах тухай” А/47 дугаар тушаалыг батлуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

5.4.4 Газрын үйл ажиллагааны үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавьж цаг үеийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлж гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллах

- ❖ Газрын цаг үеийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 сар тутмаар нэгтгэн боловсруулан батлуулж төлөвлөгөөний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж биелэлтийг гарган газрын удирдлагыг цаг үеийн мэдээ мэдээллээр тогтмол хангаж ажиллав. Нийт 11 удаагийн төлөвлөгөө, 11 удаагийн биелэл гарган хэрэгжилтэд хяналт тавьсан.

5.5 ХОТЫН СТАНДАРТЫГ ОЛОН НИЙТЭД СУРТАЛЧЛАН ТАНИУЛАХ АЖЛЫН ХЭРЭГЖИЛТ

a/. Газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажлыг хүрээнд:

- ❖ Газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар цаг үеийн мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган нийт 21 удаа телевизүүдэд ярилцлага өгч хотын стандартын талаар мэдээлэл хүргэж ажиллав.

b/. Цахим вэб хуудас болон олон нийтийн сүлжээгээр байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчлах, мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хүрээнд:

- ❖ Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах хүрээнд дараах төрлийн мэдээллийг бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтлэв.
- Үүнд:

- Цаг үеийн мэдээ – 19
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуваарь – 31
- Барилга байгууламжийн их засвар шинэчлэлт, тохижилтын ажлыг ашиглалтад оруулах комиссын хуваарь – 23
- Зарлагдсан сул орон тооны мэдээлэл – 3
- Тендерийн урилга – 29
- Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам – 3
- Газрын даргын тушаал – 49
- Санал авч буй хотын стандартын төсөл – 2
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс ажиллах үе шат, дараалал – 3
- Санал авч буй журамын төсөл – 1
- Хотын стандартын зөвлөгөөний мэдээлэл – 1

Хотын стандарт боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төсөлд санал авах ажилд зориулан 2 төрлийн баннер хийж байгууллагын фэйсбүүк хуудас болон нийслэлийн мэдээ, мэдээллийн нэгдсэн портал сайт www.ulaanbaatar.mn-д байршуулав.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

Манай байгууллагын бүтэц орон тоо нь 2022 онд шинэчлэн батлагдсанаар 59 орон тоотой байхаар батлагдаж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 43 албан хаагч буюу 72.8%-н бүрэлдэхүүнтэй ажиллаж дүрмээр хүлээсэн чиг үүрэг, стратеги зорилтуудаа төлөвлөгөөний дагуу тусгасан зорилтуудаа амжилттай хэрэгжүүлж ажилласан байна.

Тус газар нь 2022 онд 4 бүлэгт хамаарах 18 зорилт бүхий 59 ажил үйлчилгээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай хариуцлагын гэрээ байгуулсан. Хариуцлагын гэрээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөг 98.7 хувьтай биелүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуйлан Нийслэлийн Засаг даргын тамгийн газарт тайлagnаж ажиллав. Энэ жилд дараах онцлох томоохон зорилт, арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- ❖ Улаанбаатар хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх замаар хувь нэмрээ оруулах үндсэн зорилтод ажлаар Хотын стандартын **1 дүгээр ээлжийн 9 бүлгийн 38** стандартуудыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн V хуралдаанаар хэлэлцүүлэн амжилттай батлуулж 2022 оны 10 дунгаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлж эхэлсэн.
- ❖ Хотын стандартыг мөрдүүлэх ажлын хүрээнд НЗД-ын А/851 дүгээр захирамжаар төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлэв
- ❖ Хотын стандартыг мөрдүүлж эхэлсэнтэй холбогдуулан “Хотын стандартын нэгдсэн зөвлөгөөн”-ийг Хотын соёл, Хотын үйлчилгээ, Барилгын аюулгүй орчин, Иргэдийн ая тухтай орчин зэрэг салбар, чиглэлээр зохион байгуулж нийт 2300 гаруй иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Энэхүү нэгдсэн арга хэмжээ нь хотын стандартын тогтолцоог хөгжүүлэх, хотын стандартыг иргэд олон нийтэд сурталчилан таниулж, цаашид амжилттай мөрдүүлэхэд өндөр ач холбогдолтой арга хэмжээ боллоо.
- ❖ Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас Монгол улсын Шадар сайд, Барилга хот байгуулалтын сайд, Эрчим хүчний сайдуудтай байгуулсан гэрээний дагуу 2022 онд Засгийн газрын зарим чиг үүргийг Нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх хүрээнд 13 арга хэмжээний хэрэгжилтийг хангуйж холбогдох тайлан, мэдээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэв.
- ❖ Жилийн эцсийн ажлын тайлангийн хурлаа 2022 оны 12 дугаар сарын 28-ны зохион байгуулж ур чадвараараа хэлтэс, хамт олноо манлайлан ажилласан 14 албан хаагчдаа Барилга хот байгуулалтын яам, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг дарга, Монголын залуучуудын холбооны шагналуудаар тус тус шагнаж урамшууллаа.
- ❖ Хотын стандартыг боловсруулах, батлуулах журам, Хотын стандартын зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг дүрмийг боловсруулан 2023 онд батлуулахаар ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:

ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН
ДАРГА /С.ТӨМӨРДУЛАМ/

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА /Э.ДАВААХАТАН/

ТАЙЛАН БИЧИЖ НЭГТГЭСЭН:

ЗАХИРГАА САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН

ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН /Б.ЖАРГАЛ/